



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 03 дугаар сарын 30-ны өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-7
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	8-44

1. “Женев хотноо 1958 онд баталсан “Дугуйт тээврийн хэрэгслүүд, тэдгээрт суурилуулан ашиглаж болох тоног төхөөрөмж, эд ангид зориулсан Нэгдсэн Үндэстний Байгууллагын уялдуулан тохируулсан техникийн дүрмийг хэрэглэх болон эдгээр дүрэмд үндэслэн олгосон баталгааг харилцан хүлээн зөвшөөрөх нөхцөлийн тухай хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.01.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах, үргэлжилнэ/	10-11
2. Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл, Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл /Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2023.01.30-ны өдрийн хоригийг хүлээж авсантай холбогдуулан боловсруулсан/	11-14
3. Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.01.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	14-16
4. Аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн эдийн засаг дахь оролцоог нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл нарын 6 гишүүн 2022.08.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	16-44

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
03 дугаар сарын 30-ны өдөр /Пүрэв гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 75 гишүүнээс 38 гишүүн хүрэлцэн ирж, 50.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 11 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Ё.Баатарбилэг, Х.Нямбаатар, Ч.Хүрэлбаатар, Д.Цогтбаатар;

Эмнэлгийн чөлөөтэй: Г.Мөнхцэцэг, Ш.Раднаасэд, Б.Энх-Амгалан;

Хоцорсон: С.Амарсайхан -15 минут, Г.Амартүвшин -13 минут, С.Батболд -1 цаг 15 минут, Б.Бейсен -25 минут, Х.Болорчулуун -13 минут, Н.Ганибал -57 минут, Т.Доржханд -47 минут, Б.Жавхлан -1 цаг 13 минут, М.Оюунчимэг -1 цаг 04 минут, Д.Өнөрболор -12 минут, Д.Сарангэрэл -10 минут, Б.Саранчимэг -15 минут, Ц.Туваан -40 минут, Ж.Чинбүрэн -25 минут, Ж.Эрдэнэбат -1 цаг 25 минут.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуягаас ирүүлсэн албан бичгийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг үг хэлэв.

Нэг. “Женев хотноо 1958 онд баталсан “Дугуйт тээврийн хэрэгслүүд, тэдгээрт суурилуулан ашиглаж болох тоног төхөөрөмж, эд ангид зориулсан Нэгдсэн Үндэстний Байгууллагын уялдуулан тохируулсан техникийн дүрмийг хэрэглэх болон эдгээр дүрэмд үндэслэн олгосон баталгааг харилцан хүлээн зөвшөөрөх нөхцөлийн тухай хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.01.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах, үргэлжилнэ/

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Н.Цогтсайхан, Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Баярсайхан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан референт Б.Гандиймаа нар байлцав.

“Женев хотноо 1958 онд баталсан “Дугуйт тээврийн хэрэгслүүд, тэдгээрт суурилуулан ашиглаж болох тоног төхөөрөмж, эд ангид зориулсан Нэгдсэн Үндэстний Байгууллагын уялдуулан тохируулсан техникийн дүрмийг хэрэглэх болон эдгээр дүрэмд үндэслэн олгосон баталгааг харилцан хүлээн зөвшөөрөх нөхцөлийн тухай хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийн хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 41

Татгалзсан: 9

Бүгд: 50

82.0 хувийн саналаар хууль батлагдлаа.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./10:23/

Уг асуудлыг 10 цаг 23 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл, Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл /Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2023.01.30-ны өдрийн хоригийг хүлээж авсантай холбогдуулан боловсруулсан/

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Н.Цогтсайхан, Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан референт Б.Гандиймаа нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Занданшатар: Байнгын хорооноос гаргасан Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 46

Татгалзсан: 8

Бүгд: 54

85.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах

тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүдийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд шилжүүлэв./10:28/

Хуулийн төслүүдийг эцэслэн батлах

Г.Занданшатар: 1.Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 47
Татгалзсан: 7
Бүгд: 54

87.0 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

2.Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 45
Татгалзсан: 9
Бүгд: 54

83.3 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

3.Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 42
Татгалзсан: 12
Бүгд: 54

77.8 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

4.Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 44
Татгалзсан: 10
Бүгд: 54

81.5 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

5.Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 46
Татгалзсан: 8
Бүгд: 54

85.2 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох

тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулиудын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулиудын эцсийн найруулгатай танилцлаа./10:32-10:33/

Уг асуудлыг 10 цаг 33 минутад хэлэлцэж дуусав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэх асуудлыг 10 цаг 35 минутаас 16 цаг 15 минутад хаалттай горимоор хэлэлцэв. Уг асуудлыг хэлэлцэх хуралдааны дэгтэй холбогдуулан Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан тайлбар хийв.

Гурав.Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.01.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Зам, тээврийн хөгжлийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга М.Энхболд, мөн яамны Далай ашиглалт, усан замын тээврийн хэлтсийн дарга Д.Жавхлан, Хуулийн хэлтсийн дарга С.Мяндасмаа, Төмөр замын тээврийн хэлтсийн дарга Х.Итгэлт нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцаг Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлэгт буцаах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 38

Татгалзсан: 22

Бүгд: 60

63.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Горимын санал дэмжигдсэн тул Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг дахин анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд буцаав.

Уг асуудлыг 16 цаг 22 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв. Аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн эдийн засаг дахь оролцоог нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл нарын 6 гишүүн 2022.08.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг дэмжих хэлтсийн дарга Б.Алтантулга, Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Я.Эрдэнэсайхан, Жендэрийн үндэсний хорооны нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга Т.Энхбаяр, “Хүний эрх, дэвшилтэт бодлогын хүрээлэн”-гийн захирал Х.Баасанжаргал, “Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадвар судалгааны төв”-ийн захирал Б.Лакшми, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын “Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн зөвлөл”-ийн дарга Б.Мөнхзул, мөн зөвлөлийн гишүүн Р.Сансармаа, зөвлөх Л.Болормаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Н.Цогтсайхан, Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Д.Нарантуяа, референт Г.Нямсүрэн, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг нар танилцуулав.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар “Дэлхийн эмч нарын өдөр”-ийг тохиолдуулан мэндчилгээ дэвшүүлэв./16:34/

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг, Х.Булгантуяа, Д.Өнөрболор, Т.Доржханд, Т.Энхтүвшин, Б.Баярсайхан, Б.Жаргалмаа, Ц.Сэргэлэн нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл, М.Оюунчимэг, Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Я.Эрдэнэсайхан, Жендэрийн үндэсний хорооны нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга Т.Энхбаяр, “Хүний эрх, дэвшилтэт бодлогын хүрээлэн”-гийн захирал Х.Баасанжаргал, “Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадвар судалгааны төв”-ийн захирал Б.Лакшми, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын “Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн зөвлөл”-ийн дарга Б.Мөнхзул, мөн зөвлөлийн гишүүн Р.Сансармаа, зөвлөх Л.Болормаа нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Ц.Мөнхцэцэг, Ц.Цэрэнпунцаг нар үг хэлэв.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар Аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн эдийн засаг дахь оролцоог нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 13

Бүгд: 40
67.5 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн эдийн засаг дахь оролцоог нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 18 цаг 03 минутад хэлэлцэж дуусав.

Бусад. Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатарын урилгаар Нийслэлийн Баянгол дүүргийн ерөнхий боловсролын сургуулиудын ахлах ангийн сурагчдын дунд зохион байгуулсан “Шилдэг бизнес 2023 төсөл”-ийн оролцогчид, Улсын Их Хурлын гишүүн Б.Дэлгэрсайхан, Т.Энхтүвшин нарын урилгаар Дорноговь аймгийн Мандах сумын иргэдийн төлөөлөл, Баянхонгор аймгийн ерөнхий боловсролын “Эрдэм” сургуулийн багш, ажилчдын төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайхан, Ц.Сандаг-Очир нарын урилгаар Нийслэлийн Багануур дүүргийн иргэдийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатарын урилгаар Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын ерөнхий боловсролын сургуулийг 1995 онд төгссөн төгсөгчдийн төлөөлөл Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн нээлттэй хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч М.Номиндулам, С.Энхзаяа нар хариуцан ажиллав.

Нээлттэй хуралдаан 2 цаг 09 минут үргэлжилж, 75 гишүүнээс 68 гишүүн хүрэлцэн ирж, 90.7 хувийн ирцтэйгээр 18 цаг 03 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 03 дугаар сарын 30-ны өдөр,
Пүрэв гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 11 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. Ирц бүрдсэн байна. Ингээд Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 3 дугаар сарын 30-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэгдүгээрт, Женев хотноо 1958 онд баталсан дугуй тээврийн хэрэгслүүд тэдгээрт суурилуулан ашиглаж болох тоног төхөөрөмж, эд ангид зориулсан НҮБ-ын уялдуулан тохируулсан техникийн дүрмийг хэрэглэх болон эдгээр дүрэмд үндэслэн олгосон баталгааг харилцан хүлээн зөвшөөрөх нөхцөлийн тухай хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэнэ. Үргэлжлүүлэн хэлэлцэнэ. Одоо санал хураалт үлдсэн байгаа. Эцэслэн батлах санал хураалт үлдсэн байгаа. Хоёрдугаарт, Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүдийг хэлэлцэнэ. Гуравдугаарт, Улсын Их Хурлын гишүүдийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэх асуудлыг хэлэлцэнэ. Дөрөвдүгээрт, Төмөр замын тээврийн

тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна. Тавдугаарт, Аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн эдийн засаг дахь оролцоог нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ. Зургаадугаарт, Монгол Улсын эрдэнэсийн сангийн үндсэн сангийн орлого, үндсэн болон гүйлгээний сангийн зарлагын 2023 оны төсвийн тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу 17 цагаас өмнө өчигдөр хэлэлцэхээр тогтсон асуудлын тов дараалалд өөрчлөлт оруулах, асуудал нэмэх горимын санал оруулах тухай саналаа Норовын Алтанхуяг гишүүнээс ирүүлсэн байна. Ингээд Норовын Алтанхуяг гишүүний бичгийг бол танилцуулъя. Тэгээд өнөөдрийн хэлэлцэх асуудалтай холбогдуулж үг хэлэх тийм зөвшөөрөл саналыг өчигдөр 12 цагт ирүүлсэн байна. Ингээд Норовын Алтанхуяг гишүүн үг хэлнэ.

Н.Алтанхуяг: Эрхэм гишүүдийн өглөөний амгаланг айлтгая. Би 1, 2 асуудлаар 1 санал хэлье гэсэн юм. Эхнийх нь энэ Улсын Их Хурлын гишүүдийн бүрэн эрхийг түдгэлзүүлэхтэй холбоотой асуудлаар одоо юу гэдэг юм нэг зовлон үзсэн чавганц гэдэг юм уу, 2 санаа хэлье. Ер нь бол Улсын Их Хурал бид ард түмнээс сонгогдсон элч төлөөлөгчид манай ард иргэдийн мэдэх эрхийг их боогдуулж байна. Өнгөрсөн жил байна уу одоо нэг яг жилийн өмнө 4 сард бас 1 хэдэн гишүүдийн бүрэн эрхийг түдгэлзүүлнэ гэж орж ирсэн. Улс орон даяар ингээд л гэмтэй хулгайч гээд л ингээд нэг хэдэн хүнийг зарладаг. Энэ Монгол Улсын Үндсэн хуулиар бол гэм

буруутай нь шүүхээр эцэслэн тогтоогүй тогтоогдоогүй байхад хэнийг ч гэсэн гэмтэн гэж үзэх ёсгүй л дээ.

Тэгэхдээ ямар буруу практикт тогтоож байна вэ гэхээр Улсын Их Хурал дээр орж ирж зарладаг, эсвэл энэ үүдний эндээс одоо тэр хууль хяналтын байгууллагынхан зарладаг. Хэд хоноод юм уу, хэдэн сарын дараа хүмүүсийнх нь нэр нь солигдож орж ирдэг. Бид нар ийм юм байхгүй, бид нар тийм юм хийгээгүй гэхээр нь тийм үү тэгвэл өөр хүн байх юм байна гээд хайгаад олдог юм уу яадаг юм. Тэгээд өөр хүмүүс орж ирдэг. Ингэснээр энэ хуулийн байгууллагын нэр хүнд бол би бол уначихлаа гэж харж байна. Улсын Их Хуралд итгэх одоо иргэдийн итгэл ч бас уначихлаа. Эд нар чинь тоглоом зугаа хийгээд байгаа юм биш үү? Хэн нь гэмтэй, хэн нь гэмгүйг ерөөсөө энэ хууль хяналтын байгууллага чинь тогтоож чадахаа больчихсон юм биш үү. Энэ дарга нар нь ч юм уу, хэн нэгэн этгээдүүд эд нарт захиалга өгөөд хуулийнхан маань даалгавраар ажилладаг болчхоод байгаа юм биш үү гэсэн ийм л юм иргэд хэлж байна шүү дээ. Та нар одоо үг хэлдэггүй юм уу, одоо яагаад байгаа юм бэ? Хэн чинь гэмтэй, хэн чинь гэмгүйг нь ерөөсөө мэдэхийн арга алга. Баахан гишүүдийн нэр зарлаад л, тэгээд тэр нь дараа нь хэн ч биш болдог. Ийм одоо их муу юм болж байна эрхэм гишүүдээ.

Тийм учраас би юу гэж хэлж байна вэ гэхээр Улсын Их Хурал дээр энэ Улсын Их Хурал дээр оруулж ирээд олон нийтэд гэмтэн гэж зарлачхаад, тэгээд хэдүүлээ I хаалгаа хааж аваад хаалттай хуралддаг энэ нэг горимыг нь яаж өөрчлөх юм өөрчилмөөр байна. Ил тод ярья. Хэн чинь хулгайч, хэн чинь гэмтэй, хэн чинь гэмгүйг бас нэг ил яримаар байх юм. Тэгэхгүй бол энэ зөвхөн Ардын намынхны хоорондын тоглоом биш байна. Энэ улс орны хувь заяагаар тоглосон тоглоом болох вий гэж би санаа зовж хэлж байна. Дахиад эндээс би нэг юм хэлье. Их Хурал дээр

түдгэлзүүлнэ баахан юм болж явчхаад шүүх дээр юу хууль хяналтын байгууллага шууд шүүх рүү шидчихэж байна. Ядаж шүүхээ ингээд нээлттэй болгоод өгөөч дээ, ард иргэд мэдэх эрхтэй баймаар байна шүү дээ. Ямар гэгчийн гэмт хэрэг хэн хийчихсэн юм, яамаар байна гэхээр хаалттай. Тийм учраас миний горимын санал бол Занданшатар даргаа энэ тогтоол гаргах ёстой юм байна. Улсын Их Хурлын гишүүдтэй холбоотой асуудлыг шүүх бол ил тод шийдмээр байна, нээлттэй хиймээр байна. Юундаа айгаад байгаа юм, юунаасаа хулчийгаад байгаа юм. Гэтэл Улсын Их Хурлын гишүүд айхгүй энэ ил тод хийлгэе гэж байхад тэр доор гүйцэтгэх албаны хүмүүс нь өмгөөлөгчөөрөө дамжуулаад хаалттай болгож хувиргаад байна. Энийг нэг мөр шийдмээр байна.

Хоёрдугаарх нь бол шударга бусын эсрэг энэ хээл хахууль авлигын эсрэг Монгол хүн ядарсан Монгол иргэд маань баялагтаа эзэн болохын төлөө тэмцэж байгааг нь бол зөв зүйтэй зүйл гэж үзэж байгаа юм. Энэ бол чухал зүйл, хэцүү зүйл, маш их бэрхшээл зовлон дундуур явна. Өмнөх парламентууд ч гэсэн ийм байсан. Тэгэхдээ өмнө нь том, том хуйвалдагч нар байсан учраас энэ асуудал олигтой яваагүй. Тэгэхдээ одоо бид нар Их Хурлын гишүүд шүү дээ. Та нарт ярьдаггүй юм уу, хэлдэггүй юм уу, ард иргэд бид нарт хэлж байна шүү дээ. Үгүй ээ энэ бизнес эрхэлж байгаа хүмүүс хавар боллоо шүү дээ гэж. Үгүй ээ хавар болохоор яадаг юм. Үгүй ээ хавар болохоор уг нь нэг жаахан ажил хөдөлмөр өрнөдөг юм даа, эхэлдэг юм даа. Та нар чинь тэр хавиар нэг хэдэн наашаа цаашаа хэдэн хүнийхээ асуудлыг ярихаас өөр юм хийдэггүй юм байна. Тийм учраас би бас юу гэж хэлэх гэж байна вэ гэхээр манай иргэдийн хэлээд байгаа үнэн, бизнес эрхэлж байгаа хүмүүсийн хэлээд байгаа нь бас зөв байна. Энэ ард иргэд энэ юмны үнийн өсөлтийг зогсоох талаар Их Хурал яримаар байна. Алга болж байгаа

дундаж давхаргаа дэмжих үү, яах вэ яаж босгох вэ гэдгээ яримаар байна. Одоо хаврын ажил төрөл эрхэлж байгаатай холбогдуулаад бизнесүүдийг яаж дэмжих юм бэ? Энэ бодлогын асуудлууд бол энэ өнөөдрийн ярьж байгаа юм уу, энэ ойрын үед яригдаж байгаа асуудлууд дунд ороод хоцорч үлдэх ёсгүй юм. Баярлалаа.

Г.Занданшатар: Тэр үнийн өсөлттэй эдийн засгийг тогтворжуулах тэлэхтэй холбоотой асуудлаар Эдийн засгийн байнгын хороо хэлэлцэхээр төлөвлөж байгаа. Холбогдох байгууллагуудтай хамтраад төсөл боловсруулж байгаа гэж ойлгож байгаа.

Шүүн таслах ажиллагаанд бол хөндлөнгөөс оролцож болохгүй үндсэн хуулийн 49.2-т Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын ба Засгийн газрын гишүүн, төр, нам, олон нийтийн бусад байгууллагын албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй гээд Үндсэн хуулийн 49.2-т заачихсан. Тэгээд энийгээ Шүүхийн хууль бусад хуульд заачихсан. Ийм шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг гэж Ардчилсан Үндсэн хуультай улсууд тооцогддог юман дээр бол бид нар энд шүүхийн ажиллагааг энд хэлэлцэх юм уу, нөлөөлөх ийм бол Үндсэн хууль зөрчсөн хэрэг болно гэдгийг бас сануулчихъя.

Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё. Ер нь бол яах вэ асуудлуудыг нээлттэй хэлэлцэж болно, нээлттэй хэлэлцье гэсэн санаа гэж ойлголоо. Тэрнийг бол горимын санал гэж үзээд өнөөдөр гишүүдийн бүрэн эрхийг түдгэлзүүлэхтэй холбоотой асуудлыг нээлттэй, хаалттай биш нээлттэй хэлэлцэх бололцоо юу байн вэ, энэ Тамгын газар судлаад цаанаасаа нууцаар ирчихсэн юмыг нээлттэй хэлэлцэж болж байна уу, үгүй, санал хураалтаар шийдэж болж байна уу лавлагаа

танилцуулаарай тухайн үед нь. Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг. “Женев хотноо 1958 онд баталсан “Дугуйт тээврийн хэрэгслүүд, тэдгээрт суурилуулан ашиглаж болох тоног төхөөрөмж, эд ангид зориулсан НҮБ-ын уялдуулан тохируулсан техникийн дүрмийг хэрэглэх болон эдгээр дүрэмд үндэслэн олгосон баталгааг харилцан хүлээн зөвшөөрөх нөхцөлийн тухай хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.01.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах, үргэлжилнэ/

Женев хотноо 1958 онд баталсан дугуй тээврийн хэрэгсэл, тэдгээрт суурилуулсан тоног төхөөрөмж, эд ангид зориулсан НҮБ-ын уялдуулан тохируулсан техникийн дүрмийг хэрэглэх болон эдгээр дүрэмд үндэслэн олгосон баталгааг харилцан зөвшөөрөх тухай зөвшөөрөх нөхцөлийн тухай хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг үргэлжлүүлэн хэлэлцэнэ. Гишүүд асуулт асууж, үг хэлж дууссан байгаа. Санал хураалт явуулна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.2-т заасны дагуу нэгдсэн хуралдаанаар эцэслэн батлах санал хураалт явуулна. Нийт гишүүдийн олонх дэмжсэнээр хуулийн төслийг эцэслэн баталсанд тооцно. Байнгын хорооны саналаар Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Гишүүд суудалдаа суугаарай. Өнөө өглөөний бүртгэлийн санал хураалт явуулъя. Бүртгэлд ороогүй гишүүдийг тасалснаар тооцож байгаа гэдгийг сануулчихъя. Гадуур, дотуур явж байгаа гишүүд орж ирж бүртгэлдээ ороорой. Содномын Чинзориг сайд Дэлхийн эрүүл мэнд, эмч нарын өдөр болж байгаа энэ чуулганд оролцож байгаа байх. Цэрэнпунцаг, өөр нэг гишүүн энд хэн харагдав. Хассуурийн Ганхуяг гишүүн сая байсан хаачсан бэ? Даваасүрэн сайд,

Болорчулуун сайд 2 хаачсан юм бэ, дуудаарай.

Байнгын хорооны саналаар Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 41 гишүүн дэмжиж, хуулийн төсөл батлагдлаа. Гишүүд ажлын хэсэгт баярлалаа. Хуулийн төслийг уншиж, хуулийг уншиж танилцуулъя. Хэлэлцээр соёрхон батлах тухай. 1 дүгээр зүйл. Швейцар Улсын Женев хотноо 1958 онд батлагдсан дугуй тээврийн хэрэгслүүд тэдгээрт суурилуулан ашиглаж болох тоног төхөөрөмж, эд ангид зориулсан НҮБ-ын уялдуулан тохируулсан техникийн дүрмийг хэрэглэх болон НҮБ эдгээр дүрэмд үндэслэн олгосон баталгааг харилцан зөвшөөрөх нөхцөлийн тухай хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай. Эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцсугай. Дараагийн асуудалд орно.

10.23 цаг

Хоёр. Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл, Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл /Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2023.01.30-ны өдрийн хоригийг хүлээж авсан тухай холбогдуулан боловсруулсан/

Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль хүчингүй

болсонд тооцох тухай, Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүдийг хэлэлцэнэ. Энэ бол Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авсан тухай холбогдуулаад хүчингүй болгох тухай хуулийн төслүүд Байнгын хороо санаачилсан байгаа. Төслийн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны дарга Баагаагийн Баттөмөр танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Баттөмөр: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2023 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн хоригийг 2023 оны 3 дугаар сарын 17-ны өдөр Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн уг хорь хоригийг хүлээн авч Ерөнхийлөгчийн хоригийн тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолыг баталсан. Хоригийг хүлээж авсан тухай холбогдуулан 2023 оны 3 дугаар сарын 28-ны өдөр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 88.9 дэх хэсэгт заасныг үндэслэн Байнгын хорооноос боловсруулсан Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл, Харилцаа, холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл, Хүний хувийн мэдээлэл

хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх төслүүдийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, санал гаргаагүй бөгөөд хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хуулийн төслүүдийг дэмжсэн болно. Тус хуулийн төслүүд нь Байнгын хорооны санал, дүгнэлтийг та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл, Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл болон хуулийн төслүүдийг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, хуулийн төслүүдийг баталж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу? Алга байна. Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Кибер аюулгүй

байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлгээр нь батлах Байнгын хорооны саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалт. Сайд нар суудалдаа сууя. Жамбалын Ганбаатар, Сандагийн Бямбацогт, Сайнбуянгийн Амарсайхан, Хаянгаагийн Болорчулуун гишүүн сайн байна уу? 30 минут хоцорлоо. Санал хураалт. 46 гишүүн дэмжиж 85.2 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Байнгын хорооны саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн учраас төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд шилжүүлж байна. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.3-д заасны дагуу долоо хоногийн баасан гараг бүрийн өглөө 10 цагаас нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийг эцэслэн батлах бөгөөд өөр цагт ирц хангалттай бол эцэслэн батлах санал хураалт явуулна гэж заасан. Энэ заалтын дагуу Байнгын хороо төслүүдийг эцэслэн батлуулах хувилбаруудыг бэлтгэж гишүүдэд тараасан байна. Эцэслэн батлуулахад бэлэн болсон байна.

Одоо төслүүдийг эцэслэн батлах санал хураалт явуулна. Үүний өмнө зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Жамбалын Ганбаатарын урилгаар Баянгол дүүргийн ерөнхий боловсролын сургуулиудын ахлах ангийн сурагчдын дунд зохион байгуулсан Шилдэг бизнес 2023 төслийн оролцогчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Улсын Их Хурлын гишүүдийнхээ нэрийн өмнөөс эрхэм

хүндэт сурагчид та бүхэнд сурлага, хөдөлмөрийн өндөр амжилтыг хүсэн ерөөе. Сурах чиглэлийг эрхэм болгоорой. Энэ тийм шилдэг бизнес тэр, ер нь сургуулиудад тэр *entrepreneur* буюу энэ аж ахуй бизнес эрхлэх арга ухааныг дэлхийн бүх сургуулиудад хөдөлмөрийн хичээл, иргэний хичээл сэдвийн дор ордог. Тэгээд энийг бас хөгжүүлж байгаа нь Баянгол дүүрэг сайшаалтай байна. Тэгээд та бүхэнд өндөр амжилт хүсэн ерөөе.

Одоо санал хураалт явуулна. Нийт гишүүдийн олонх дэмжсэнээр хууль эцэслэн батлагдана. Нийт гишүүдийн олонх буюу 39-өөс дээш гишүүн дэмжиж байж хуулийн төслүүд эцэслэн батлагдана гэдгийг сануулъя. Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 47 гишүүн дэмжиж хууль эцэслэн батлагдлаа.

2.Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 45 гишүүн дэмжиж хууль эцэслэн батлагдлаа.

Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 42 гишүүн дэмжиж хууль эцэслэн батлагдлаа.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 44 гишүүн дэмжиж хууль эцэслэн батлагдлаа.

5.Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 46 гишүүн дэмжиж хууль эцэслэн батлагдлаа. Хуулийн төслүүд батлагдлаа.

Одоо батлагдсан хуулиудын эцсийн найруулгыг сонсьё. Олон нийтийн сүлжээнд Хүний эрхийг хамгаалах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. 2.Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алган байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Хуулийн эцсийн найруулгыг сонслоо.

Хориг хүлээж аваад хүчингүй болчихсон хуулийг ингээд заавал хүчингүй болгодог нэг ийм дэгийн процедурууд их л хүндрэлтэй байгаа юм даа. Энэ заавал. Дараагийн асуудалд орно.

10.33 цаг

Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэх асуудлыг хэлэлцэнэ. Монгол Улсын ерөнхий

прокуророос саналаа нууцын зэрэглэлтэй ирүүлсэн. Байнгын хороод, Халдашгүй байдлын дэд хороо бол хаалттай хуралдсан. Сая энэ гишүүд ч гэсэн ирүүлсэн саналыг үндэслээд Улсын Их Хурлын Тамгын газар энийг хуульд нээлттэй хэлэлцэх ямар бололцоо байна гэдгийг түрүүн асуусан. Бас энэ нуугаад байх ч юу байх вэ, төрийн нууцтай холбоотой асуудал биш бол нээлттэй хэлэлцэж болдоггүй юм уу гэсэн асуудлаар. Санал хураалтаар шийдэж болохгүй юу? Энэ 81 Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга.

Л.Өлзийсайхан: Монгол Улсын Их Хурлын тухай, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 12.2 дахь хэсэгт Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22.2-т заасан асуудлыг нууцын горимоор хаалттай хуралдаанаар хэлэлцэнэ гэж хуульчилсан байгаа. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22.2 дахь хэсэгт бол хаалттай хэлэлцэхээр хуульд заасан болон төрийн нууцтай холбоотой асуудлыг хаалттай хуралдаанаар хэлэлцэнэ гэж хуульчилсан байгаа. Тэгэхээр уг асуудал маань Төрийн болон албаны нууцын тухай хуульд заасны дагуу нууцын зэрэгтэй орж ирсэн байгаа.

Г.Занданшатар: Албаны нууцад хамаарч байгаа юм байна тэгвэл тийм ээ. Мөрдөн шалгах ажиллагааны нууцтай холбоотой. Ингэвэл Монгол Улсын Ерөнхий прокуророос нууцын зэрэглэлтэй ирүүлсэн асуудал учраас хаалттай хуралдаанаар хэлэлцэхээр хуульчлагдсан юм байна. Чуулганы нэгдсэн хуралдааныг хаалттай хэлэлцүүлгийн горимд шилжүүлбэ.

Хуралдаан 10 цаг 35 минутаас 16 цаг 15 минутад хаалттай горимоор үргэлжлэв.

Г.Занданшатар: Нээлттэй горимд шилжсэн үү? Агар-Эрдэнэ дарга нааш ир. Зүгээр шилжүүлж болох уу, заавал санал хураалтаар шилжих үү?

Нээлттэй горимд шилжсэн үү? Дараагийн асуудалд орно.

Гурав.Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.01.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна. Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Бат-Эрдэнэ танилцуулна. Индэрт урьж байна.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын.../үг тасрав/

Г.Занданшатар: Аюурсайхан гишүүнээ нэг санал, Амарсайхан гишүүний нэг санал хураалт байна. Нэг санал хураалт.

Ж.Бат-Эрдэнэ: 2023 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн. Эдийн засгийн байнгын хорооны 2021 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн 03 дугаар тогтоолоор Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнээр ахлуулж, гишүүдэд

А.Адъяасүрэн, Б.Энх-Амгалан,
Б.Баттөмөр, Д.Бат-Эрдэнэ, Б.Жавхлан,
М.Оюунчимэг, С.Чинзориг нарын
бүрэлдэхүүнтэйгээр байгууллаа.

Байнгын хороо 2023 оны 3 дугаар сарын 26-ны, 28-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасныг баримтлан дээрх хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж, дээрх санал дараах санал, дүгнэлтийг гарган та бүхэнд танилцуулж байна. Байнгын хорооны хуралдаанаар төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед ажлын хэсгээс төмөр замын зурвас газар хамгаалалтын бүсийн газрын асуудлаарх зохицуулалт болон төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах, тасралтгүй байх зарчмын зарчмыг алдагдуулахгүйгээр төмөр замын суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч тээвэрлэгчид гэрээ байгуулан ажиллах зохицуулалтыг илүү тодорхой болгох, төмөр замын суурь бүтэц бүтэцтэй 1 түвшинд огтлолцох, авто зам болон бусад төрлийн суурь бүтцийн зураг төслийг боловсруулахдаа төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцдөг байхаар өөрчлөн найруулах санал бэлтгэснийг хуралдаанд оролцогч гишүүдийн олонх нь дэмжсэн болно.

Түүнчлэн төмөр замын суурь бүтцийн болон хөдлөх бүрэлдэхүүний эд ангийг үйлдвэрлэх, угсрах, засварлах үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр хэрэгжүүлэх, төмөр замын тээвэртэй холбогдох зөвшөөрлийн харилцааг хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэж, тусгай зөвшөөрлийг төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгодог байх, төмөр замын тээврийн тарифыг нээлттэй, оновчтой тогтоох асуудлыг асуудлаар дүгнэх зөвлөмж гаргах үүрэг бүхий Төмөр замын тээврийн тарифын орон тооны бус зөвлөл бий болгох зэрэг санал бэлтгэснийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжлээ.

Мөн Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ төслийн 14 дүгээр зүйлийн 14.1.2 дахь заалтыг заалтын Төмөр замын суурь бүтэц ашиглах тусгай зөвшөөрөл 14.1.4 дэх заалтын төмөр замын тээвэрлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн 1 хуулийн этгээдэд давхардуулан олгох, давхардуулан олгохыг хориглох тухай санал гаргасныг хуралдаанд оролцогч гишүүдийн олонх дэмжлээ. Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны төсөл дүгнэлтийг зарчмын хувьд зарчмын зөрүүтэй саналын томъёоллуудыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлт зарчмын зөрүүтэй саналуудыг шийдвэрлэн хэлэлцэн шийдвэрлэхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Эдийн засгийн байнгын хороон дарга Цэрэндамбын Цэрэнпунцаг.

Ц.Цэрэнпунцаг: Энэ Төмөр замын хууль дээр бас ажлын хэсэг нэмж ажиллах шаардлагатай. Ганц нэг саналууд дээр бас санал хураалт явуулах шаардлагатай байгаа юм. Тэгээд дараагийн долоо хоногт Байнгын хорооны хурлаар нэг анхны хэлэлцүүлэгт нь буцааж өгөх хэрэгтэй байна. Дараагийн долоо хоногт манай ачаалал бага байгаа учраас бол энийг энэ Байнгын хороон дээрээ энийгээ дахиж нэг

хэлэлцмээр байгаа юм даргаа. Тийм учраас энийг анхны хэлэлцүүлэгт нь буцааж өгнө үү.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүд чинь хоцорч ирсэн сая. Ахиад хэлэлцүүлэг явуулах шаардлагатай анхны хэлэлцүүлгийг. Тэгээд энэ горимын саналаар санал хураалт явуулна. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 48.1-д заасны дагуу шаардлагатай гэж үзвэл олонх дэмжвэл анхны хэлэлцүүлэгт буцаана гэсэн дэгтэй. Ингээд энэ хуулийг анхны хэлэлцүүлэгт буцаах горимын саналаар санал хураалт явуулна. Доржханд гишүүнээ санал хураалтаа өгөөрэй. 68 гэдэг чинь 30. Горимын саналаар санал хураалт явуулъя. Гишүүд анхааралтай байгаарай Анхны хэлэлцүүлэгт Байнгын хороонд нь буцаах горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалтад 60 гишүүн оролцож, 38 гишүүн дэмжиж, 63.3 хувийн саналаар санал дэмжигдлээ. Анхны хэлэлцүүлэгт дахин бэлтгүүлэхээр Байнгын хороонд Эдийн засгийн байнгын хороонд буцааж байна. Эдийн засгийн байнгын хороо анхны хэлэлцүүлгийг дахиж явуулна. Байнгын хорооны 31 зарчмын зөрүүтэй санал байсан тэрнийг Эдийн засгийн байнгын хороонд илжжүүлээ буцааж. Дараагийн асуудалд оръё.

16.22 цаг

Дөрөв.Аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн эдийн засаг дахь оролцоог нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл нарын 6 гишүүн 2022.08.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн эдийн засаг дахь оролцоог нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн

мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ. Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Даваажанцангийн Сарангэрэл танилцуулна. Индэрт урьж байна. Та хаачих нь вэ, хөөе Батболд дарга.

Д.Сарангэрэл: Улсын Их Хурлын дарга эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Сарангэрэл, Адъяасүрэн, Анужин, Баярсайхан, Булгантуяа, Жаргалмаа, Г.Мөнхцэцэг, Ц.Мөнхцэцэг, Одонтуйя, Оюунчимэг, Өнөрболор, Саранчимэг, Ундрам нарын эмэгтэй гишүүд бид 22 оны 8 дугаар сарын 19-ний өдөр Аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн эдийн засаг дахь оролцоог нэмэгдүүлэх тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн билээ.

Сүүлийн жилүүдэд дэлхий нийтээр жендерийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох үйл ажиллагаа улам эрчимтэй явагдаж байна. Дэлхийн улс оронд эмэгтэйчүүдийн эдийн засаг дахь бодит оролцоог нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлдэг сайн жишиг хэдийнээ тогтоод байна. Эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих, эдийн засгийн хувьд чадавхжуулах нь улс орны бизнесийн орчныг бүхэлд нь эрчимжүүлээд зогсохгүй гэр бүлийн орлого өсөх, амьдралын чанар сайжрах, хүүхдийн эрүүл мэнд, боловсролд оруулах хөрөнгө оруулалт 4 дахин нэмэгддэг тухай судалгаа байгаа нь нийгмийн олон асуудлыг цогцоор нь шийдвэрлэх чухал хөшүүрэг гэж үздэг.

Улмаар эмэгтэйчүүдийн эдийн засаг дахь оролцоо нэмэгдэх нь хүн амын өсөлт улс орны ирээдүйн хөгжилд онцгой чухал үүрэгтэй. Манай улс бизнес эрхлэгч эмэгтэйчүүдтэй холбоотой ангиллыг эрх

зүйн хүрээнд албан ёсоор тодорхойлж, төр бодлогоор дэмжих талаар нарийвчилсан эрх зүйн зохицуулалтгүй явсаар өнөөг хүрлээ. Нэгдсэн Үндэстний Байгууллагын хөгжлийн хөтөлбөр болон холбогдох байгууллагуудын хийсэн судалгаагаар Монгол Улсад бизнес эрхлэгчдийг хүйсээр ангилсан тоон мэдээлэл дутмаг байна. Энэ нь эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлэх боломжийг хязгаарлаж байна. 2021 оны ААН-ийн тооллогоор нийт 147000 ААН бүртгэгдсэнээс 37 хувь нь эмэгтэй, 63 хувь нь эрэгтэй захиралтай байна. Эдийн засгийн тэргүүлэх салбар болох уул уурхай, барилга, эрчим хүч, зам тээврийн салбарт эрэгтэй захирал 80-аас дээш хувь, худалдаа үйлчилгээ, хунсний салбарт эмэгтэйчүүд давамгайлж байна.

НҮБ-ын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд тусгаснаар нийгмийн харилцааны бүхий л салбарт хүйсийн тэнцвэртэй байдлыг хангах нь тогтвортой хөгжлийн суурь гэж үздэг. Энэ хуулийн төслийг боловсруулах болсон хууль зүйн үндэслэл. Эмэгтэйчүүдийг алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай конвенцын 11 дүгээр зүйлийн 1-д эрэгтэй, эмэгтэйчүүдэд ажлын хувьд тэгш хандах, ажлын чанарыг адил үнэлүүлэх, банкны зээл авах, үл хөдлөх хөрөнгө барьцаалах болон бусад хэлбэрээр санхүүгийн зээл авах эрхээр хангах тухай олон улсын өмнө хүлээсэн үүргээ бид биелүүлэх болно.

Мөн Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод хүн амын бүлэг бүрийн онцлогт нийцсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.2.8-д нийгмийн амьдралын бүх хүрээнд эмэгтэйчүүд үр дүнтэй оролцох, манлайлан ажиллах тэгш боломжоор хангана гэж заасныг ажил хэрэг болгох боломж бүрдэх юм. Эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжсэн хуулийн төслийн ач

холбогдлыг товчхон мэдээлье. Хүйсээр ангилсан нэгдсэн мэдээллийн сан бий болж, түүнд суурилсан төрийн бодлого хөтөлбөр хэрэгжинэ. Бодлого хөтөлбөрийн хэрэгжилтэд үнэлгээ хийх замаар санхүүгийн хөшүүргүүд зорилтот бүлэгтээ хүрнэ. Олон улсын санхүүгийн төрөлжсөн үйлчилгээнүүдэд эмэгтэй бизнес эрхлэгчид хамрагдах боломж бүрдэнэ.

Банк санхүүгийн байгууллагууд эмэгтэй бизнес эрхлэгчдэд ээлтэй банк санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрүүлэх хөшүүрэг болно. Жендерийн мэдрэмжтэй төсвийн төлөвлөлт хэрэгжих боломж мөн бүрдэх юм. Ижил төрлийн бизнес эрхлэгч эмэгтэйчүүд хоршоолон хамтарч ажиллах боломжууд нээгдэнэ. Өнөөдөр дэлхийн 35 орон эмэгтэй бизнес эрхлэгч хэн бэ гэдгийг тодорхойлсон хуультай байна. Азийн хөгжлийн банкны судалгаагаар эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжсэнээр ДНБ-ийг 16.1 хувиар өсгөх боломжтой байдаг байна. Тэгвэл микро буюу гэр бүлийн түвшинд жендерийн эрх тэгш байдал хангагдсанаар гэр бүлийн хүчирхийлэл буурна гэж 2020 онд 100 ААН-ийн дунд хийсэн судалгаанд оролцогчдын 87 хувь нь дүгнэжээ. Тиймээс эмэгтэй гишүүд бид Аж ахуй эрхлэгчдийн аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн эдийн засаг дахь оролцоог нэмэгдүүлэх тухай анхдагч хуулийн төслийг боловсруулан та бүхэндээ танилцуулж байна.

Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн эдийн засаг дахь оролцоог нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэхийг дэмжиж өгөхийг та бүхнээсээ хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Хууль санаачлагчид баярлалаа. Төслийн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Мөнхөөгийн Оюунчимэг танилцуулна. Индэрт урьж байна.

М.Оюунчимэг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл, А.Адъяасүрэн, П.Анужин, Б.Жаргалмаа, Г.Мөнхцэцэг, Ц.Мөнхцэцэг, М.Оюунчимэг, С.Одонтуяа, Б.Саранчимэг, Ч.Ундрам нараас 2022 оны 8 дугаар сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн эдийн засагт оролцоог нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төрийн оролцоог нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Нийгмийн бодлогын байнгын хороо 2023 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хуулийн төсөлд аж ахуй эрхлэгч эмэгтэй нэр томъёог тодорхойлох, аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдээс бүрдсэн хуулийн этгээдийн тодорхойлолтыг тухайлан хуульчилснаар мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээ авах байгууллага ФАТФ-ийн зөвлөмжийн 24 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангах бол улмаар хуулийн этгээдийн ил тод байдал хангагдаж, Олон улсын байгууллагаас санхүүжилт авах боломж бий болох, хуулийн төсөлд тусгасан дэмжлэг гэдэг нь аль нэг хүйсийн аж ахуй эрхлэгчийг онцгойлон дэмжиж байгаа харилцаа биш. Гагцхүү хэрэгжүүлж байгаа бодлогын 40-өөс доошгүй хувийг аж ахуй эрхлэгч эмэгтэй бүрдүүлэх, доод шалгуурыг тогтоох, орон нутгийн түвшинд аж ахуй эрхлэгч эмэгтэй бүрдүүлэх аж ахуй эрхлэлтийг

дэмжих бодлого хэрэгжүүлэх тохиолдолд эмэгтэй аж ахуй эрхлэгчийг хамруулах талаар тухайлан зохицуулахаар тусгасан байна.

Хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ болон үндэсний хууль тогтоомж, мөн урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогод нийцсэн нийгмийн нэг бүлгийг төлөөлж эдийн засаг бизнесийн орчинд үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийг төр хувийн хэвшилээс дэмжих эрх зүйн орчин бүрдэх бөгөөд улсын төсөвт нэмэлт ачаалал үүсэхгүй гэж төсөл санаачлагчид үзэж байна. Иргэдийн оролцоог хангах, санал авах зорилгоор Байнгын хорооноос хуулийн төслийг Улсын Их Хурлын Parliament цахим хуудаст байршуулан санал авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг 2020 оноос хойш буюу Ковид 19 цар тахлын халдварын үеэс Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлсэн Арван их наядын хөтөлбөр Сангийн яам, Азийн хөгжлийн банк зэрэг бусад эх үүсвэрээс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүдэд бизнес эрхлэхэд эмэгтэйчүүдийг хамрагдсан хувь хэмжээ тус төсөл хөтөлбөрүүдэд хамрагдаж чадаагүй шалтгаан нөхцөлийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Бейсен хуулийн төслийн зарим заалт нь Монгол Улсын Үндсэн хууль болон Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуультай нийцэж байгаа эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Чинзориг хуулийн төслийн нэр томъёо аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүд гэсэн ойлголтод албан бус секторт хөдөлмөр эрхэлж буй эмэгтэйчүүд хамрагдах эсэх талаар, мөн аж ахуй эрхэлж байгаа бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг төрөөс дэмжих дэмжлэгийг оновчтой тодорхойлсон эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Чинбүрэн хуулийн төсөлд тусгагдсан Төрийн болон орон нутгийн

өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийг тэргүүн ээлжид хамруулах талаар судалгаа тооцоолол хийсэн эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Идэрбат хуулийн төсөл батлагдсанаар Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сан болон бусад хөгжлийн сангуудаас аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүд тэргүүн ээлжид хөнгөлөлттэй зээл авах эсэх боломжтой эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Туваан хуулийн төсөлд малчин эмэгтэйчүүд болон хөдөө аж ахуй газар тариалангийн салбарт ажиллаж буй эмэгтэйчүүдийн оролцоог хэрхэн хангах талаар асуулт асууж хариулт авсан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн эдийн засаг дахь оролцоог нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Г.Занданшатар: Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Борхүүгийн Дэлгэрсайхан, Төмөртоогоогийн Энхтүвшин нарын урилгаар Дорноговь аймгийн Мандах сумын иргэдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс сайн сайхныг хүсье. Эмч нар байгаа юу, үгүй юу? Тийм, манай Содномын Чинзориг сайд байна. Тэгээд өнөөдөр Дэлхийн эмч нарын өдөр тохиож байна. Дэлхий нийтээр аливаа улс орны хөгжлийн түвшинг эдийн засгийн хөгжлийн хөгжлийн өсөлтөөр хэмжихээс зайлсхийж хүний дундаж наслалтын

өсөлтөөр хэмжиж байгаа. Хүний хөгжилд гол асуудлаа хандуулдаг болсон. Хүний хөгжил ямар байна гэдэг. Хүний хөгжлийг хэмждэг гол үзүүлэлтүүдийн нэг бол нэг гол үзүүлэлт нь бол хүн амын дундаж наслалт байдаг.

Тэртээ 1950 оноос хойш Монгол хүний дундаж наслалт бараг 2 дахин өслөө, одоо 71-д хүрч байна. Энэ бол бас нийгмийн хөгжлийн ч үр дүн. Манай эрүүл мэндийн байгууллага, эмч, эмнэлгийн ажилтнуудын хичээл зүтгэлийн үр дүнд дундаж наслалт 71 хүрч байгааг бас цохон тэмдэглэж байна. Ковид цар тахлын хүндрэлийг даван туулахад ч гэсэн манай эмч, эмнэлгийн ажилтнуудын нөр их хөдөлмөр өндөр үүрэг гүйцэтгэснийг бид мартаагүй байна. Тийм учраас өнөөдөр энэ Монголын, Дэлхийн эмч нарын өдрийг тохиолдуулан хүн амын эрүүл мэндийг дэмжих хамгаалах ариун үйлст эрдэм мэдлэг хүч чадлаа харамгүй зориулан ажиллаж байгаа эмч нартаа эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөе. Мандах сумын эмчдээ бас Дэлхийн эмч нарын өдрийн мэндийг дэвшүүлъя. Та бүхэндээ баярлалаа.

Ингээд хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу? Тасаллаа. Бадарчийн Жаргалмаа гишүүнээр тасаллаа. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. 2 дарчихсан байна. Цэдэвийн Сэргэлэн гишүүнийг нэмье. Сэргэлэн гишүүнийг асуултад нэмж байна.

Ажлын хэсгийг танилцуулъя. Борын Алтанхундага Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөр эрхлэлтийг эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Хөдөлмөр эрхлэлт ажлын байрыг дэмжих хэлтсийн дарга, Ядамсүрэнгийн Эрдэнэсайхан Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга. Хуулийн төсөл боловсруулсан ажлын хэсгийн нэрсийг

танилцуулъя. Төмөр-Өлзийгийн Энхбаяр Жендерийн үндэсний хорооны нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга, Хүрэлбаатарын Баасанжаргал Хүний эрх дэвшилтэт бодлогын хүрээлэнгийн захирал, хуульч, Боожоогийн Лакими Эдийн засгийн бодлого өрсөлдөх чадвар судалгааны төвийн захирал, хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийн нарийн бичгийн дарга, Баасангийн Мөнхзул Монгол үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн зөвлөлийн дарга, Жүр-Үр ХХК-ийн захирал, хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийн гишүүн, Рэнцэндоржийн Сансармаа Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн зөвлөлийн гишүүн, Траст трейд ХХК-ийн захирал, хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийн гишүүн, Лувсандоржийн Болормаа Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн зөвлөлийн зөвлөх. Хаянгаагийн Болорчулуун гишүүн ажлын хэсгийн гишүүн, Содномын Чинзориг гишүүн асуулт асууна.

С.Чинзориг: Би энэ яах вэ эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт аж ахуй эрхлэлтийг дэмжих чиглэлээр бас эмэгтэйчүүд бас санаачилга гаргаад ийм хуулийн төсөл оруулж ирж байгааг нь бол сайхан сайшааж байгаа юм. Гэхдээ миний хувь хүний бодол бол арай өөр өнцгөөс нь харвал яасан юм бэ гэсэн бодолтой бол байгаа юм. Аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн эдийн засгийн оролцоог нэмэгдүүлэе гэдэг ийм хуулийн төсөл орж ирсэн юм байна лээ. Би өчигдөр Байнгын хороон дээрээс бол ярьсан юм. Миний санал санаа бол эмэгтэйчүүдийн эдийн засаг дахь оролцоог нэмэгдүүлэх гэдэг ийм өргөн утгаар нь уг нь энэ хуулийг харсан бол зөв биш байсан юм болов уу гэсэн ийм саналаа хэлсэн л дээ. Энэ талаас нь манай ажлын хэсгүүд юу гэж үзсэн юм. Ингээд өргөн утгаар нь уг нь харсан бол

илүү үр дүнтэй байх байсан болов уу. Яах вэ аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн эдийн засгийн оролцоог нэмэгдүүлнэ гэдэг нь бол нэг л тал нь л даа. Эмэгтэйчүүдтэй холбоотой, хөдөлмөр эрхлэлттэй холбоотой ажил эрхлэлттэй аж ахуй эрхлэлттэй холбоотой олон асуудлууд бол бий.

Тухайлбал эмэгтэйчүүд хөдөлмөр эрхэлж байгаа эмэгтэйчүүдийн маань дийлэнх нь албан секторт хөдөлмөр эрхэлдэг шүү дээ. Тэгэхээр энэ хууль батлагдсанаар энэ албан бус секторт хөдөлмөр эрхэлж буй эмэгтэйчүүдийг яаж эрх ашгийг нь хамгаалах юм. Тэдгээрт ямар дэмжлэг үзүүлэх юм. Ер нь албан бус секторт хөдөлмөр эрхэлж буй эмэгтэйчүүдийг яаж албан хэвшилд шилжүүлэх вэ эд нар гээд асар их яг хийх ярих ёстой асуудлууд байгаа юм. Энийг та бүхэн юу гэж бол хараад байгаа юм бэ?

Хоёр дахь асуудал нь эмэгтэйчүүдийн үнэлэгдээгүй хөдөлмөр асар ихтэй гэж манай эмэгтэйчүүд өөрсдөө ярьдаг. Тэгээд энэ хуульд чинь энэ эмэгтэйчүүдийн үнэлэгдээгүй хөдөлмөрийг яаж үнэлэмжтэй болгох юм бэ гэдэг асуудал яригдахгүй байгаа юм. Эмэгтэйчүүдийн эдийн засаг дахь оролцоог нэмэгдүүлэх, дээшлүүлэх чиглэлээр гэсэн ийм хуулийн төсөл орж ирсэн бол миний яриад байгаа энэ эмэгтэйчүүдийн үнэлэгдээгүй хөдөлмөрийг үнэлэмжтэй болгох асуудал уг нь яригдах бай байсан болов уу гэж бол бодоод байгаа юм.

Гурав дахь асуудалд нь энэ эмэгтэйчүүдийн ялангуяа орлогыг энэ орлоготой болгох асуудал маш их чухал. Ялангуяа манай эхчүүд эмэгтэйчүүдийг хүүхэд гаргаж байгаа нь улс орныхоо хөгжилд оруулж байгаа хувь нэмэр асар их хөрөнгө оруулалт гээд л бид яриад л байдаг. Эсрэгээрээ хүүхэд төрүүлсэн эх 3 жилийн хугацаанд хүүхдээ харна гэвэл амьдрал нь бүр хүндэрчхэж байгаа юм шүү дээ. Цалин байхгүй, орлого байхгүй

болчихдог. Яах вэ бид нар өмнө нь Хөдөлмөрийн яаманд ажиллаж байхдаа энэ хугацааных нь нийгмийн даатгалын шимтгэл тасалдахгүй төлөгддөг байя гээд нэг Нийгмийн даатгалын хуульд өөрчлөлт оруулаад, ядаж нийгмийн даатгалын шимтгэл, эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нь тасалдахгүй төлөгддөг хууль, эрх чинь орчин бүрдүүлсэн.

Цалин хөлс нь байхгүй болоод ингээд эх хүн хүүхэд гаргасан биш бүр өөрөө ингээд амьдралаараа хохирчхож байгаа ийм асуудлууд байгаа юм. Энэ асуудлуудыг та бүхэн яаж харж байгаа юм бэ? Энэ асуудлууд байгаа учраас би бол зөвхөн аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн эдийн засгийн оролцоог нэмэгдүүлэх биш эмэгтэйчүүдийн ерөөсөө эдийн засаг дахь оролцоог нэмэгдүүлэх гэдэг ийм өргөн утгаар нь авч үзсэн бол илүү оновчтой үр дүнтэй байх бас байсан юм биш шүү биш биз дээ гээд ингээд бодоод байгаа юм. Манайхан нэг юм ярьж байгаад л хаячихдаг юм. Чимээгүй болчих юм. Нэг хэсэг энэ Оюунхорол гишүүний үед билүү дээ нэг эмэгтэйчүүдийг дэмжсэн эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжсэн төрөлжсөн банк байгуулна гээд л баахан шуугьсан л даа. Үгүй ээ тэр маань юу болчов, хааччихав, сураг байхгүй. Тэрэн шиг энэ та бүхний маань энэ хууль ингээд гараад тэгээд сүүлдээ нэг хэрэгжүүлэхэд хэцүү, хэрэгжихгүй байхад хэцүү хэрэгжээд үр дүн гарсан юм байхгүй тийм тунхаглалын хууль болчих вий дээ гэж би жсоохон болгоомжлол байгаа юм. Та бүхэн өөрсдөө юу гэж бол хараад байгаа юм бэ? Худалдан авах аж ажиллагаа дахь хуульд өөрчлөлт оруулна гээд байгаа юм. Эмэгтэй захиралтай бол тэгээд худалдан авах ажиллагаанд давуу эрх олгох юм уу? Сүүлдээ магадгүй манайхан бүх.../минут дуусав/

Г.Занданшатар: Хууль санаачлагч Даваажанцангийн Сарангэрэл гишүүн.

Д.Сарангэрэл: Баярлалаа.

Г.Занданшатар: Содномын Чинзориг, Чинзориг сайд суу. Дэлхийн эмч нарын өдөр болохоос биш таны.

Д.Сарангэрэл: Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Чинзориг одоо бол бас Эрүүл мэндийн сайд, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн даргаар ажиллаж байгаа. Манайхан жсоохон чимээгүй байх уу. Тэгээд арга байхгүй бас энэ нийгмийн даатгалтай холбоотой хөдөлмөр эрхлэлттэй холбоотой асуудлыг бол хэнээс ч илүү мэднэ. Тэр утгаараа энэ хуулийн төслийг ер нь бас өргөн харья гэдэг энэ санаачилгыг Байнгын хороон дээр ч гэсэн хэлсэн. Бид нар бас энийг бодох ёстой зүйл. Ингээд хэлэлцэх эсэх нь шийдэгдчихвэл ажлын хэсгийн түвшинд асуудлыг бас харья гэдэг нэг зүйлийг ярьж байгаа юм.

Нөгөө талаас бас хууль боловсруулахдаа энэ асуудлыг бодоогүй биш бодсон, санаагүй биш санасан юм байгаа юм. Гол нь ерөөсөө бид нар яг таны хэлээд байгаа албан бус сектор буюу хувиараа бизнес аж ахуй эрхэлж байгаа эмэгтэйчүүдийгээ хоршоолуулах, тэдгээрийнхээ борлуулалт болон бизнесээ өргөжүүлэх тэр боломжийг нь бүрдүүлэх. Өөрөөр хэлэх юм бол албан бус бизнесийг албан болгож эмэгтэй бизнесийг дэмжих төрийн бодлогын гадна талд нь биш дотор талд нь оруулах тийм томоохон зорилт тавьсан юм байгаа юм. Тэгээд энийг бол тэгэхдээ таны энэ хэлж байгааг бас ажлын хэсгийн түвшинд бол ярих ёстой гэдэг дээр бид нарт санал нэг байгаа. Энд бол ер нь эмэгтэйчүүдээ зөвхөн үр хүүхдээ харах, үр хүүхдийнхээ эрүүл мэнд, боловсролд хөрөнгө оруулах, айл гэрийнхээ ахуй амьдралыг дээшлүүлэхээс гадна улс орныхоо эдийн засагт хувь нэмэр оруулах тэр том үүд хаалга нь болох юм.

Бид сая би танилцуулгадаа хэлсэн тийм ээ. Азийн хөгжлийн банкны судалгаагаар эмэгтэй бизнес эрхлэгчдээ дэмжсэн хуультай улс орон ДНБ-ээ 16.1 хувиар нэмсэн ийм тооцоо судалгаа байдаг. Энэ бол маш том тоон үзүүлэлт. Бид нар энэ рүү алхах анхныхаа үүд хаалгыг л нээх гээд байгаа ийм зорилготой. Мэдээж хэрэг бол бүх зүйлийг багтааж чадаагүй, бүх зүйлийг бол бас тооцож чадаагүй байж болно. Ер нь бас аливаа хуулийн хэрэгжилтийг 2-3 жилийн дараа үнэлгээ дүгнэлт хийгээд, саяын гишүүдийнхээ ярьж байгаа тодорхой детальчилсан шийдлүүдийг бас оруулах боломжтой гэсэн ийм байдлаар бол таны саналын дараа бид нар ажлын хэсэг тэр дор нь хуралдаад бас энэ асуудалд хандсан байгаа.

Чинзориг сайд их чухал зүйл ярьж байгаа. Бид нар энэ хуулиар ерөөсөө манай үндэсний бизнес эрхлэгчдийн өнөөгийн нөхцөл байдал ямар байгаа юм бэ гэдэг нийт үндэсний мэдээллийн сантай болоод, энэ мэдээллийн сан дээрээ үндэслээд эрэгтэй, эмэгтэй хүйсийн байдлыг ялгаварлахгүйгээр төрийн бодлогыг боловсруулах, улмаар энэ бодлогодоо чиглэсэн бодит үйл ажиллагаа явуулах бололцоо нээгдэнэ гэж ингэж үзэж байгаа юм. Тийм учраас энэ хуулийн ач холбогдол нь бол энэ байгаа юм. Сая Чинзориг сайдын нэг чухал хэлээд байгаа зүйл эмэгтэйчүүдийн хөлсгүй хөдөлмөрийн асуудлын талаар манай эмэгтэйчүүд ярьдаг. Энэ хуулийн төсөл батлагдах юм бол ямар үр дүн гарч энэ нөхцөл байдал бас илаарьших юм бэ гэдэг асуудлыг тавьж байна. Манай ажлын хэсгийн гишүүд маань бол бас нэлээн сайн судалсан, нэлээн сайн мэдээлэлтэй байгаа учраас энэ асуудалд болон саяын Чинзориг сайдын асуулттай холбоотой миний хариулт дээр ажлын хэсгийн гишүүдээ нэмэлт хариулт өгөхийг хүсэж байна, манай хариулах гишүүд өөрсдийнхөө өмнө байгаа тоогоо өргөөрэй. Баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн 81, 89 юм уу?

Л.Болормаа: Эрхэм Их Хурлын гишүүдэд бүгдээрэнд нь энэ өдрийн мэндийг хүргэе. Миний нэр Болормаа. Би Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн зөвлөлийн даргаар 8 жил ажиллаж байгаад манай залгаа үе маань эхэлчихсэн байж байгаа. Яг энэ Чинзориг сайдын гишүүний асуусан асуултууд бол бүгд зөв асуулт. Энэ дээр би яг ийм хэд хэдэн тоо баримтыг хэлмээр санагдаж байна. Сая ковидын үед Азийн хөгжлийн банкнаас энэ гэр хорооллын өрхийн бизнесүүдэд хэрхэн дэмжих вэ гэдэг ийм төслийг хэрэгжүүлсэн. Энэ төслийг ингээд харахад албан бусаар үйл ажиллагаа явуулж байгаа бүх байгууллагуудын 60-70 хувь нь дан эмэгтэйчүүд байна. Энэ эмэгтэйчүүд нь яагаад албан бус байгаа вэ гээд тэгэхээр ажлын байрны хүртээмж байхгүй нэгд. Хоёрдугаарт ААН-үүд нь жижигхэн. Ийм асуудлуудаар эд нар ингээд өөрийн эрхгүй албан бус руу орж байна.

Би ганцхан жишээ ярья. Эмэгтэй, эрэгтэй 2 хүн үйлдвэрт ажиллаж байгаад үйлдвэр нь нүүгээд явахад тэд нар өглөө орой явах боломжгүй болоод шууд өрхөөрөө ядуурал руу орж байгаа. Ингээд хэдэн баримт хэлэх юм бол манай ААН-үүдийн 83 хувь нь 1-10хан хүнтэй ийм ААН-үүд байгаа. 50 хүнээс илүү ААН нь ердөө 3.1 хувь. Тэгэхээр энэ ажлын байр ААН гэж ингэж яаж байж хүртээмжээ авна. Хоёрдугаарт судалгаа бол Азийн хөгжлийн банкны үед төрөөс хэрэгжүүлсэн энэ олон дэмжлэг маань өрхийн бизнест хүрч үү гэдгийг бол манай эмэгтэйчүүдийн зөвлөлөөс энийг бол бүр удирдаад ингээд 2000 хүнийг судлаад, орон нутаг, хотод судлахад албан бус байгууллагын албан бусаар үйл ажиллагаа явуулж байгаа өрхийн бизнесүүд төрийн ямарваа нэгэн дэмжлэгийг авах ямар ч боломжгүй байгаад байгаа.

Тэгэхээр эд нар ямар нэгэн байдлаар албан үйл ажиллагаандаа орж байж энэ нь бол хэрэгжих ёстой байгаад байгаа юм. Жендерийн яг энэ хуулийг хэрэгжүүлсэн орнууд бол олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны орнууд бөгөөд хөгжингүй орнууд бүгдээрээ орж байгаа. Тэд нарын бол жижиг, дундын дотоодын нийт бүтээгдэхүүндээ оролцуулж байгаа оролцоо нь бол 40-60 хувь байж байгаа.

Гэтэл манай Монгол улсын жижиг, дундын ДНБ-д оролцож оруулж байгаа оролцоо нь ердөө 5.4. Хууль батлагдсанаар 4.9-өөс 5.5 болж ийм бага байгаад байгаа. Тэгэхээр албан бус байгаа эмэгтэйчүүдийгээ яаж албан сектор руу хүлээж хөтөлж оруулах вэ. Тэгээд тэд нартаа яаж дэмжлэг үзүүлэх вэ гэхээр яах арга байхгүй энэ том бизнесүүдтэйгээ уяж, бид нар нэмүү өртөг гэж ярьдаг нэмүү өртгийн сүлжээгээр ингэж явах ёстой. Тэгэхээр энэ хууль нь эрх гишүүд та бүгд хэрэв дэмжих юм бол тэгш давуу эрхийг олгох биш, тэгш боломжийг бий болгох, бодлогыг чадвар, чадамжтай, хүртээмжтэй ийм байдлаар хийх ийм бололцоог үзүүлж байгаа.

Ганцхан жишээ хэлээдэхье. Манай энэ гэр хорооллын төслөөр эмэгтэйчүүд хоршоо болсон. Хоршоо болонгуут тэр ААН болчихож байгаа. ААН болонгуут орлого нь 50 саяасаа 200 сая болсон. Хамтын хүчээр тэд нар тоног төхөөрөмжтэй болсон. Тоног төхөөрөмжтэй болсноороо санхүүгийн зээлд орж чаддаг болсон. Тэгэхээр жендерийн энэ эмэгтэйчүүдийнхээ тодорхойлолтыг байгуулсан орон бий болгосон орнууд нь дандаа хөгжингүй орнууд байна. Энийгээ дэвшүүлээгүй. Энэ эдийн засгийн яг энэ үйл ажиллагаанд оролцож байгаа бүтэц нь манайхтай адилхан дандаа жижиг бичил байгаа орнууд нь дандаа Энэтхэг, Шри-ланка, Бангладеш гээд ингээд хөгжиж хөгжлийнхөө үе шатыг давж авч чадахгүй байгаа орнууд байгаад байгаа

юм. Тэгэхээр бид нар энэ шилжилтийн үеийн бий болчихсон энэ эдийн засгийн үйл ажиллагааны энэ бүтцийг өөрчилж шинэчлэх хэрэгтэй байна. Бид нар дараа дараагийнхаа үеийг энэ өрхийн бизнес буюу ядуурал руу түлхэж оруулахгүй байхын төлөө яаж хамтран ажиллах вэ гэдгийн төлөө энэ хууль бол гарч ирж байгаа гэж ойлгож болно. Ажлын байр байж, ААН-үүд нь хүчтэй байж ядуурал мөн өрхийн бизнесүүдийгээ бид нар бол ингэж дэмжих ийм боломжууд байгаад байгаа юм.

Өрхийн бизнесээрээ байгаад албан бус байгаа нөхцөлд энэ ямар ч өөрчлөлт гарахгүй. Жилээс жилд ажил хийж байгаа хүмүүсээсээ татаас буюу халамжийн бодлого явахаас өөр ямар боломж.../минут дуусав/

Г.Занданшатар: Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн асуулт асууна.

Х.Булгантуяа: Би бас санаачлагчдын нэгийн хувьд дэмжиж үг хэлье гэж бодож байгаа юм. Эмэгтэйчүүдийн ингээд асуудлыг ярихаар эмэгтэйчүүд заримдаа давуу эрх эдлэх гээд.../үг тасрав/

Г.Занданшатар: Энэ үг биш, асуулт тавьж байгаа шүү дээ. Үг дараа нь хэлнэ.

Х.Булгантуяа: Тэгээд юу яачихъя тодруулчихъя дарга. Эмэгтэйчүүдийн асуудлыг ярихаар бид нарыг нэг илүү давуу эрх эдлэх гээд байна гэж нийгэмд их зөв, буруу ойлголт яваад байдаг. Үнэнийг хэлэхэд Монгол Улсын Үндсэн хуулиар бид иргэн болгон 18 эрхийг баталгаатай эдэлнэ гэж байдаг ч гэсэндээ хүн болгон тэгж чаддаггүй. Хаана төрсөн, заримдаа эрэгтэй, эмэгтэй, хот хөдөөгөөрөө тэгээд ямар эцэг эхтэй төрснөөрөө, хөгжлийн бэрхшээлтэй үгүйгээрээ заримдаа бид нар яг ижил тэгш эрхийг эдэлдэг үү гэвэл үгүй. Тэгэхээр Монгол Улсын бусад хуулиуд яах ёстой вэ гэхээр ижил тэгш

боломжийг олгож, ижил тэгш эрхийг нь харин олгохын төлөө бусад хуулиуд нь зохицуулагдаж явдаг юм.

Манай эмэгтэй бизнес эрхлэгчдийн хувьд нэг хэд хэдэн проблемууд байгаад байгаа юм. Нэгдүгээрт манай энэ Азийн соёл юм даа. Манай нийт эмэгтэйчүүдийн дөнгөж 33 хувь нь орон сууц эзэмшдэг. Эрэгтэйчүүдийн 60 орчим хувь нь эзэмшдэг газар дээр мөн адилхан. Голцуу бид нар чинь өрхийн тэргүүн гээд га байгаа ганц өмч хөрөнгөө нөхрийнхөө нэр дээр л голцуу бүртгэлтэй байдаг. Эмэгтэй хүн бизнес эрхэлнэ гэхэд энүүнийг тэгээд л барьцаагүй бизнес гэж юу байх вэ? Нөхрөөсөө асууна, бараг хадмуудаасаа асууна, ээж ааваасаа асууна гээд ингээд бүхэл бүтэн энэ бол гэр бүлийн том асуудал болж нэгдүгээрт хувирдаг.

Хоёрдугаарт дээрээс нь нэмээд манай эмэгтэйчүүдийн маань хувьд барьцаа хөрөнгө байхгүй учраас дээрээс нь нэмээд ихэнхдээ л жижиг, дунд бизнес эрхэлдэг учраас голцуу жижигхэн зээл авах л ийм боломжтой байдаг. Банкны салбарын топ энэ зээлдэгч нар бол дандаа эрэгтэйчүүд байдаг юм. Тэгэхээр үүнийг бид нар бас хараад энэ эмэгтэйчүүдийн аж байдлыг нь сайжруулахад ялангуяа эмэгтэй бизнес эрхлэгч гэдэг тодорхойлолтыг оруулж өгөхгүй бол олон улсын байгууллагуудаас бас намайг Сангийн дэд сайдаар ажиллаж байхад ч гэсэндээ жоохон зээл тусламжаар янз янзын байдлаар дэмжье гэхээр нөгөө эмэгтэй бизнес эрхлэгчдээ тодорхойлж чаддаггүй. Эмэгтэй захиралтай компаниудыг нь эмэгтэй бизнес эрхлэгч гэх юм уу, эмэгтэй хүн ихэнх хувьцааг нь эзэмшдэг хүнийг нь эмэгтэй бизнес эрх гэх юм уу, эсхүл ихэнх ажилчид нь эмэгтэй байвал энүүнийг эмэгтэй бизнес гэх юм уу. Аливаа нэгэн тодорхойлж чадахгүй, манай хуульд ийм тодорхойлолт байхгүй байгаад байгаа учраас Европын сэргээн босголт хөгжлийн банкнаас, Азийн хөгжлийн

банкнаас, Жайкагаас гэдэг юм уу ийм төслүүд хэрэгжүүлье гэхээр танайд хууль нь байхгүй байна ядаж танайх хуулиа гаргачхаач дээ гэдэг энэ шаардлагыг тавьдаг юм.

Тэгээд энэ хуулийг боловсруулахад бид бас олон улсын хэд хэдэн байгууллагуудтай хамтран ажилласан. Олон улсын энэ жишигүүдийг бид нар бас авсан юм. Тэгээд бид нар энэ эмэгтэйчүүд ер нь бизнест ч, төрд ч байхаар маш их олон ажлууд амждагийн нэг том жишээ бол өнгөрсөн 2 манай парламентад 13 эмэгтэй суухад 2016-аас 22 онд би 1 ганцхан тоо жишээг дурдъя гэж бодсон юм 175 цэцэрлэг баригджээ. 2016-аас 22 оны хооронд 272 сургууль баригдсан байна, 68 дотуур байр ашиглалтад орсон байна, одоо 112 цэцэрлэг баригдаж байна, 103 сургууль баригдаж байна, ахиад 36 сургууль дотуур байр ашиглалтад орох гэж байна. Тэгэхээр энэ бүхэн бол бас эмэгтэйчүүд салбар салбартаа идэвхтэй оролцоотой байх юм бол үүний үр дүн гардгийн тод жишээ юм. Тэгээд эмэгтэйчүүд маань нэг их илүү эрхийг эд хүсээд байгаадаа биш. Тэгэхээр энэ хуулиар би манай хууль ажлын хэсгээс бүр тусгайлан асууя гэж бодож байна.

Болормаа дарга та бас улсын хэмжээний томоохон банкны системийн банкны ТУЗ-ийн гишүүний хувьд топ энэ зуун ААН-үүдийн захирлууд дотор хэчнээн нь эмэгтэйчүүд байдаг юм бэ? Дээрээс нь нэмээд танай топ зээлдэгч нар дотор хэчнээн нь өнөөдөр хувь нь эмэгтэйчүүд байдаг юм бэ энүүнийг бас бидэнд тодруулж хэлж өгөөч гэж хүссэн юм.

Г.Занданшатар: 81.

Л.Болормаа: Булгантуяа гишүүнд маш их баярлалаа. Маш зөв асуултуудыг гаргаж ирж байна. Одоо манай банкны систем Төв банкныхаа тоог гаргахад Төв банк маань ганцаараа өөрөө статистиктай ийм банк байгаад байгаа

юм. Тэр статистикаар бол бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг яг өмчлөлөөр нь хуваагаад ингээд үзэхэд бол эмэгтэйчүүд бол яах вэ 40 хэдэн хувьтай байгаад байгаа юм. Энэ нь тэгэхдээ зээлийнхээ хэмжээгээр болохоор эрэгтэйчүүдийн зээлийн хэмжээнээсээ 3 дахин байгаад байгаа юм. Тэгэхээр энэ нь бол өөрөө манай эмэгтэйчүүдийн бизнес хэр жижигхэн байгааг харуулж байгаа юм.

Манай топ зуун ААН-ийн ердөө 10-хан хувь нь эмэгтэй эзэнтэй ийм компаниуд байгаад байгаа юм. Манай жижиг, дунд гээд ингээд явахаар эмэгтэйчүүдийнх нь тоо нэмэгдээд, тэгээд доошлох тусам эмэгтэйчүүдийн бизнес эрхлэлт нь нэмэгдээд байгаа. Хамгийн харамсалтай нь албан бус байгууллага албан бусаар үйл ажиллагаа явуулж байгаагийн дийлэнх нь эмэгтэйчүүд байгаа бөгөөд өрхөө бүтнээр нь нөхөртэйгөө хүүхэдтэйгээ бүгдээрэнг нь авч яваад байгаа. Эд нарыг ердөө энэ ядуурлаас гарах ганцхан боломж нь юу вэ гээд тэгэхээр ямар нэгэн байдлаар албан болгож тэгээд энэ компаниуд нь бол дэмжиж оруулах. Би дахиад 1 жишээ хэлчихье.

Одоо манай эмэгтэйчүүдийн зөвлөлөөс хоршоо болгосон компаниа оёдлынхоо үйлдвэрийн компанитай нийлүүлэхэд тэр компанийн үйл ажиллагаа нь шууд жигдэрч байгаа. Яагаад гэвэл шууд захиалгатай болж байгаа, тэд нар тэрийгээ энд тэнд очиж зарах Нарантуулаар гүйх хэрэггүй болж байгаа. Тэгэхээр энэ манай гишүүд энд зочид байж байна маш сайн ойлгож байгаа шүү дээ тийм ээ. Ямар хэцүү байдаг вэ жижиг өрхийн бизнесүүдийг хийхэд. Тэгэхээр энэ талаас нь ингэж яриад.

Банкнүүд бол хичээж байгаа. Тэгэхдээ бид нарт бас л мөн адил яг энэ тодорхойлолт хэрэгтэй байгаад байгаа. Мэдээж Төрийн банк байж байна, Хаан Банк байж байна, манай Голомт банк байж байна. Эмэгтэйчүүдэд зориулсан

зээлийг гаргасан боловч энэ нь бол хүртээмжээ бол хаана нь ч хүрэхгүй байгаад байгаа юм. Санхүүгийн Олон улсын санхүүгийн корпорацын энэ тооцооллоор ер нь эмэгтэйчүүдийн энэ санхүүгийн хэрэгцээ бол их наяд, бүр тэрбум долларуудаар ингэж явж байгаа учраас бид нар яах арга байхгүй санхүүгийн хүртээмжийг бий болгохын төлөө энэ ААН-ийн энэ тодорхойлолтыг оруулж ирж, тэгж байж энэ манай эдийн засаг маань өөрөө томорч өрх гэрүүд маань орлоготой болох юм гэж үзэж байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Уянгын халилгүй яг товч тодорхой уг нь тоо энэ тэрээ хэлчихмээр байгаа юм л даа. Нийт жижиг, дунд бизнес эрхлэгчдийн 60 гаруй хувь нь эмэгтэй бизнес байна энэ тэр гээд ингээд зөндөө тоонууд байгаа шүү дээ. Зочид танилцуулъя. Баянхонгор аймгийн ерөнхий боловсролын Эрдэм сургуулийн багш, ажилчдын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Эрхэм хүндэт багш, сурган хүмүүжүүлэгчид боловсролын салбарын ажилтнууд та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс соён гэгээрүүлэх боловсролын их ажилд чинь өндрөөс өндөр амжилтыг хүсэн ерөөе. Өнөөдөр чинь завсарлахгүй хуралдаад асуулт хариултын цаг үргэлжилж байгаа. Бас манай эмэгтэй багш нар бас олон байна. Тэгээд бас сургуульд бас энэ entrepreneur-т их хүүхдүүдэд тийм боловсрол олгох их чухал юм байна лээ эрэгтэй, эмэгтэйгүй. Ингээд Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүн асуулт асууна.

Л.Өнөрболор: Энэ ААН-ийн одоо өсөлт нь улс үндэсний эдийн засгийн өсөлттэй бас шууд холбоотой байдаг учраас энэ олон улсад энэ чиглэлийн эрх зүйн орчин бол бодлого хөтөлбөр хэрэгжүүлэх энэ боломжууд, хэрэгжилтийг хангах энэ арга механизм тогтолцоо бол ер нь аль хэдийн ингээд бүрдсэн байгаа. Микензигийн энэ судалгаагаар ажиллах хүчний салбарт

жендерийн тэгш байдлыг хангаснаар 2025 он гэхэд бол дэлхийн ДНБ-ийг 12-28 их наяд доллароор нэмэгдүүлэх боломжтой. Харин эсрэгээрээ жендерийн ялгаатай байдал эдийн засагт ДНБ-ий 15 орчим хувьтай тэнцэх хэмжээний ийм хохирол учруулдаг гэсэн ийм судалгаа байдаг. Тэгэхээр нэн ялангуяа яах аргагүй энэ эмэгтэйчүүдэд хөрөнгө оруулах нь бол энэ жендерийн ноогдол ашиг гэгддэг ийм эдийн засгийн өсөлтөд бол маш том түлхэц өгдөг гэдгийг бол олон улсын байгууллагууд бол судлаад хэлж байгаа.

Манай улсын хувьд бол миний хөндөх гэж байгаа 1 асуудал бол өнөөдөр эмэгтэй гишүүд бас санаачилга гаргаад бас энэ эрх зүйн орчныг бол бүрдүүлж байгаа боловчиг яг эмэгтэйчүүдийн эрхэлж байгаа энэ бизнест дэмжлэг үзүүлэх асуудлыг бодлогын түвшинд тусгайлан дэмждэг энэ төрийн тодорхой бүтэц эзэн биетэй байж энэ маань өөрөө үр өгөөжөө өгнө гэдэг асуудлыг бол бид нар бол давхар ярилцаж явах нь бол би зүйтэй гэж үзэж байна. Нэн ялангуяа энэ цар тахлын болон энэ дараах үеийн хямралын мөчлөгийн энэ нөлөөлөл бүрэн арилаагүй байгаа энэ цаг үед бол бид нар энэ хууль батлахын ар дээр эдийн засгийн өсөлтөд түлхэц өгөхүйц хэмжээний бодит хэрэгжилт байх ёстой гэж бол би бас үзэж байгаа юм. Би бас бизнесийн салбарт ажиллаж байсан хүний хувиар бол бас энэ нөхцөл байдлыг бол бас мэдэж байна.

Бусад өөр улс орны энэ Засгийн газрууд ААН-үүдийн хөгжлийн бүх үе шатад тийм ээ энэ ААН-үүдийн өсөлтийг дэмжихэд чиглэсэн төрөл бүрийн бодлогыг ингээд хэрэгжүүлж байгаа. Тэр дундаа бол энэ дижитал шилжилттэй холбоотойгоор бол энэ засаглалын, менежментийн хүний нөөцийн тийм ээ, санхүүгийн, эрүүл өсөлтийн гээд цогц бодлогын арга хэмжээнүүдийг бол маш оновчтой Засгийн газраасаа бүр тусгайлан авч хэрэгжүүлж, дэмжлэг үзүүлж байгаа

энэ асуудлууд байж байгаа. Тэгэхээр манайд бол Монгол Улсад бол яг энэ чиглэлээр тодорхой бас бүтэц байна уу гээд ингээд аваад үзэхээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаман дээр Хөдөлмөр эрхлэлтийн сан гээд 1 бүтэц байна. Нөгөөдөх нь Хүнс, хөдөө аж ахуйн яам дээр Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн төв агентлаг гээд 1 агентлаг байна. Тийм ээ, энэ бүтцээр энэ хууль, эрх зүйн орчныг бол газар хөрсөн дээр нь буулгаад үнэхээр эмэгтэйчүүдийн энэ ажил эрхлэлтийн асуудлыг бол бүхэлд нь ингээд амжилттай хангаад энэ эдийн засагт нөлөөлөл үзүүлэх энэ өсөлтийг бол хангаж ажиллахад бол учир дутагдалтай юм гэж бол миний хувьд бол харж байгаа. Тэгэхээр энэ дээр бол бас давхар ярилцаж тийм ээ шийдлийг нь олж авах нь бол би зүйтэй гэж үзэж гэж байна.

Нөгөөтээгүүр энэ гол тулгамдаад байгаа асуудлын 1 бол энэ санхүүжилтийн хүртээмжийг сайжруулах, хөрөнгийн эх үүсвэрийг нээх энэ шинэлэг шийдлүүдийг олох нь бол маш чухал асуудал байгаад байгаа юм. Сая Чинзориг гишүүнтэй ч гэсэн би бас бас тодорхой хэсгээр бол санал нэгтэй байна. Өөрөөр хэлэх юм бол зөвхөн бид нар 1 хууль, эрх зүйн орчныг нь бүрдүүлээд ингээд энэ цаас үлдээх биш яг амьдрал дээр бодитоор энэ өөрөө амжилттай хэрэгжихийн тулд бол энэ нэн ялангуяа энэ төрийн бүтэц дээр бол бас тодорхой бас ярилцахгүй бол болохгүй асуудлууд байна гэж.

Энэ төрийн худалдан авалттай холбоотой асуудал бол бас энэ хууль эрх энэ хууль маань бол бас тодорхой түвшиндээ бол бас дэмжлэг болж оруулж зүйл заалтаар оруулсан байж байгаа. Ер нь бол энэ олон улсад бол энэ төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулаад эмэгтэй бизнес эрхлэлтийг дэмжих зорилгоор энэ бусад улс орнууд бол бичил болон жижиг бизнес эрхлэгчдэд.../минут дуусав/

Г.Занданшатар: Асуулт болгож ойлгох юм байна л гэж ойлгоё. Тэгээд хариулах хүн, Эрдэнэсайхан дарга 84 Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Эрдэнэсайхан.

Я.Эрдэнэсайхан: Өнөрболор гишүүний асуултад хариулъя. Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Эрдэнэсайхан. Үнэхээр энэ хууль бас үнэхээр ач холбогдолтой байгаа. Өнөөдөр эмэгтэй бизнес эрхлэгчид маань банкнаас зээлийн бүтээгдэхүүн авахад бол маш олон шаардлагууд тавьдаг. Ингээд бас илүү хүнд нөхцөлд бас тавигддаг ийм гээд ингээд судалгаагаар харагдаж байгаа юм. Мөн эмэгтэй бизнес эрхлэгчид маань авч байгаа зээлийн хэмжээ нь бага байгаад байгаа юм. Тэгээд эргэн төлөлтөө маш сайн төлдөг. Жишээлбэл Монголбанкны судалгаагаар сая 23 онд гаргасан судалгаагаар эмэгтэй бизнес эрхлэгчид бол 11 хувьтай эргэн төлөлтийн хувь сул байгаа нь 11 байгаа юм. Тэгэхдээ эрэгтэй бизнес эрхлэгчдийнх 14 гэж гарсан байгаа юм.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас зээл авсан бизнес эрхлэгчдийг бид нар эрэгтэй, эмэгтэйгээр нь судалж үзсэн. Гэхдээ эрэгтэй, эмэгтэй гэдгээ бид нар, эрэгтэйд өнөөдөр хууль, эрх зүйн бас яг тодорхойлолт байхгүй учраас эрэгтэй захиралтай болон хувьцаа эзэмшигчдийн тоо нь 50-аас дээш хувийг нь эмэгтэй бизнес эрхлэгч гэж өөрсдөө бид тодорхойлоод үзсэн. Ингээд үзэхэд бол зээлийн эргэн төлөлт бол эмэгтэй бизнес эрхлэгчид маань маш сайн буюу дал гучийн харьцаатай байгаа юм. Тэгэхээр эрэгтэй бизнес эрхлэгчдээс илүү эмэгтэй бизнес эрхлэгчид бол сайн төлдөг гэсэн ийм статистик байгаа.

Дээрээс нь бас ингээд хоршоо хэлбэрээр хөгжүүлэхэд бол бас үнэхээр эмэгтэй бизнес эрхлэгчдийн илүү түршлага, илүү энэ унаган одоо юу гэдэг юм билээ, төрөлхийн тэр чанар нь бас

илүү давуу тал болдог гэсэн ийм байгаа, ийм хариуцлагатай бизнес эрхэлдэг гэсэн.

Бүтэцтэй холбоотой бол Засгийн газраас чиглэл өгөөгүй учраас бас шууд хариулах боломжгүй байна.

Г.Занданшатар: 83 Лакими.

Б.Лакими: Эрхэм хүндэт гишүүдийнхээ энэ өдрийн мэндийг хүргэе. Тэгээд Өнөрболор гишүүний асуултад хариулъя. Хуулийн төсөлд бол тусдаа ийм юу гэдэг юм эмэгтэйчүүдийг дэмжих ийм бүтэц бий болгоно гэж бол тусгагдаагүй. Тэгэхээр ер нь бол одоогийн байдлаар бол мэдээж бас яг шууд эдийн засгийн асуудал хариуцсан энэ чиг үүргээрээ бол яаманд бол ороод явчихна.

Хоёрт бол мэдээж бас яг төрийн байгууллагуудын маш олон төрлийн ийм дэмжлэг байгаад байдаг. Жижиг, дунд үйлдвэрийн сан, Хөдөлмөр эрхлэлтийн сан, мөн түүнчлэн энэ төрийн улсын болон орон нутгийн өмчөөр энэ бараа бүтээгдэхүүн худалдаж авах гээд, хөдөө аж ахуйн тийм ээ, Хөдөө аж ахуйн сан энэ тэр гээд, Дэмжих сан гээд Хөдөө аж ахуйн хөгжлийг дэмжих сан гээд маш олон ийм сангуудын бас үйл ажиллагаанууд байгаад байдаг. Тэгэхээр эдгээрт нь бас тодорхой хэмжээгээр энэ эмэгтэйчүүдийг дэмжих тодорхой хэмжээгээр квотууд оруулж өгөх хөшүүргүүд бий болгох боломжтой байгаад байгаа болохоор энэ олон байгаа шууд жил болгон эдгээр сангуудад хуваарилагдаж байгаа төсвөөс тодорхой хувийг нь эмэгтэй бизнес эрхлэгчдээрээ эрхлэгчдээ олгосноороо бол их, бага хэмжээгээр янз янз байж болно шүү дээ энэ квот тогтоох нь. Олгосноороо бол бас эмэгтэйчүүдийг энэ бодит ийм дэмжлэг бий болгочих ингэж боломжтой гэж харж байгаа юм. Хуулийн хүрээнд баярлалаа.

Г.Занданшатар: Тогмидын Доржханд гишүүн асуулт асууна.

Т.Доржханд: Баярлалаа. Тэгэхээр нөгөө эдийн засагт оролцох эмэгтэйчүүдийн оролцоог нь нэмэгдүүлье гээд агуулгыг нь бол дэмжиж байгаа. Тэгээд хуулийн төслийг бол хэлэлцээд явах нь зүйтэй гэсэн байр суурьтай байна. Тодорхой 1, 2 асуудал асуулт байна. Энэ хуулийнх нь үндэслэлийг нь, танилцуулгыг нь, тэгээд текстийг нь уншихаар ер нь бол яг нөгөө тодорхой яг ямар асуудлууд ямар байдлаар дэмжүүлэх вэ гэдэг дээр бол ер нь нэлээн их ерөнхий орсон юм байна л гэж ойлгогдоод байна л даа. Тэгэхээр нөгөө дэмжлэг гэдэг чинь бодит байдлаар бол санхүүгийн дэмжлэг байгаа, татварын дэмжлэг бол байгаа. Тэгээд яг ямар байдлаар энийг авах юм бэ гэдэг зохицуулалт маань яг энэ хууль дээр орох юм уу, өөр байдлаар орох юм уу гээд 1 дүгээр асуулт нь.

Хоёрдугаарх нь бол энэ төслийн 6.1.5 төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авахад тэргүүн ээлжид хамруулах гээд заасан байна. Тэгэхээр яг энэ агуулга нь яг юу гэж тайлбарлах билээ. Тэргүүн ээлжид хамруулна гэхээр нөгөө хуулийн хувьд бол тэр чинь нөгөө тодорхой хөнгөлөлт бол байдаг, хөнгөлөлт нь болохоор дотоод, гадаадын бараа бүтээгдэхүүн дээр бол байдаг. Нөгөө марж *the preference of marginal* гээд тийм юм бол байдаг. Энэ агуулгыг 1 тайлбарлаад өгөөч.

Тэгээд 6.1.1-д болохоор Татварын ерөнхий хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу хөнгөлөлттэй хувь хэмжээ тогтоох замаар дэмжинэ гээд. Энэ дээр яг ямар байдлаар та нар төсөөлж байгаа юм бэ? Ямар татварын хөнгөлөлтийг та нар хүлээж байгаа юм бэ гэж. Тэгээд дараа нь энэ 6.1.2-т санхүүгийн дэмжлэгийг тэргүүн ээлжид хүртэх боломжийг бий болгоно гээд бас томъёолчихсон байна. Тэгэхээр энэ нөгөө янз янзын хөнгөлөлттэй сангуудыг ярьж байна уу? Гаднын зээл тусламжийн

санхүүжилтийн эх үүсвэрийг ярьж байна уу, аль эсвэл энэ банкны санхүүжилтийн арилжааны банкны хүрээнд хийгддэг санхүүжилтийн хүрээнд бас ярьж байна уу? Ийм тодорхой 2-3 асуулт байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Сарангэрэл Даваажанцангийн Сарангэрэл гишүүн эхлээд хариулна. Хариулт 3 минут, нэмэлт хариулт 2 минут гэж байгаа.

Д.Сарангэрэл: Баярлалаа. Манай Өнөрболор гишүүний тодруулж байгаа, Доржханд гишүүний асууж байгаа энэ зүйлүүдийг бас анхаарах ёстой юм байгаа юм. Тэгээд бид нар бол нэгдүгээрт ер нь шууд ингээд төрийн бүтэц бий болгоё тийм байгууллага байгуулъя тодорхой хувь хөнгөлөлтүүдийг детальчлаад заая гэхээсээ илүүтэй өнөөдөр ерөөсөө эмэгтэй бизнес эрхлэгч гэж хэнийг хэлэх вэ? Тэгээд энэ тодорхойлолтынхоо хүрээнд эмэгтэй бизнес эрхлэгчийг хэрхэн яаж дэмжих вэ гэж. Өнөөдрийг хүртэл ерөөсөө эмэгтэй бизнес эрхлэгчдийн тухай үндэсний хэмжээнд статистик судалгаа тооцоо ерөөсөө үндсэндээ байхгүй. Азийн хөгжлийн банк, хэсэгчилсэн байгууллагууд хийсэн зарим нэг тоо бий. Энэ тоог харахад бол зөвхөн захирлын тоог яриад байгаа юм. Нийт ААН-үүд Монгол Улсын хэмжээнд 147000 ААН байна. Үүнээс ерөөсөө 37 хувьд нь эмэгтэй захирал байгаа юм. Эмэгтэй захиралтай байна гэдэг нь тэр нь өөрийнх нь өмчлөлийн асуудал шийдэгдсэн гэсэн зүйл огтхон ч биш.

Тэгээд энэ мэтчилэн өнөөдөр бид нар үндэсний хэмжээнд энэ эмэгтэйчүүд маань бизнес эрхлэлтийн хаана нь яваа юм, нөхцөл байдал нь ямар байгаа юм, эдийн засаг дахь хувь нэмэр оролцоог нь нэмэгдүүлэхийн тулд төрийн ямар бодлого хэрэгжүүлэх юм, аль салбарт нь илүү түлхүү дэмжлэг үзүүлэх юм бэ гэдэг өнөөдөр тийм дүр зураг байхгүй байгаа юм. Өөрөөр хэлэх юм бол тийм мэдээллийн сан байхгүй. Энэ хуулиар

хамгийн түрүүнд бид энэ мэдээллийн сантай болоод, төрийн бодлогоор яг шаардлагатай салбарт нь эмэгтэйчүүдээ дэмжих тийм хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж байгаа юм. Энэ нь өөрөө анхдагч хуулийн хамгийн гол шийдэл гэж ингээж үзэж байгаа.

Яг Доржханд гишүүний саяын тавьсан мэргэжлийн хүмүүс яг л ингэж тавьж байгаа. Байнгын хороон дээр бас ийм зүйл ярьсан. Өнөөдөр бид нар нөгөө Улсын Их Хурлын тухай хууль болон Сонгуулийн тухай хуульд 1 эмэгтэйчүүдийн квот ярьдаг шиг ийм хатуу тоо хэлнэ гэхээсээ илүүтэй ерөөсөө аливаа төрийн болон олон улсын зээл хөтөлбөр хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ заавал эмэгтэйчүүдийг оруулдаг болох, энэ эмэгтэйчүүд төрийн бодлогын гадуур үлддэггүй, дотор нь байдаг ийм л нөхцөл байдлыг энэ хуулиараа эн түрүүнд нээж өгье гэсэн ийм зорилго агуулсан учраас татварын тэдэн хувийг эдэлнэ, борлуулалтыг борлуулалтыг нь ингэж шийдүүлнэ гэдэг тийм детальчилсан асуудлыг бид нар мэдэж байгаа. Тэгэхдээ ямар ч байсан эхлээд нэг ийм үүд хаалгыг нь нээгээд орхиё. Энэ татвартай холбоотой эдгээр асуудлыг бол бид нар мэргэжлийн байгууллагатай Сангийн яамтайгаа нэлээн тийм түвшинд яриад, дараа нь бид нар мэдээж 2-3 жил хуулиа хэрэгжүүлээд, бас нэг үнэлгээ дүгнэлт хийгээд саяын детальчилсан зүйлүүдийг оруулах ийм боломжтой гэж ингэж үзэж байгаа.

Үүнээс энийг бид нар санаачлаад л ерөөсөө эмэгтэйчүүд хэрэв үйлдвэрлэл эрхлэх юм бол тэдэн хувийн хөнгөлөлт эзэлнэ эдэлнэ гэдэг шууд ийм хатуу заалтуудыг оруулахгүй байгаад, эхлээд олон улсын жишгийн дагуу дэлхийн 35 оронд хэрэгжиж байгаа эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжсэн хуулийн дагуу нэг ийм бизнес эрхлэгчийн тухай хуультай болъё гэсэн ийм зорилго агуулсан юм байгаа юм. Тэгээд манай бизнес

эрхлэгчид маань санал нэмэх үү миний хэлсэн дээр мэдээлэл нэмэх үү?

Г.Занданшатар: 80.

Б.Мөнхзул: Сайн байцгаана уу? Аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн эдийн засаг дахь оролцоог нэмэгдүүлэх тухай дэмжих тухай энэ хуулийн төслийг санаачилсан гол шалтгаан нь болохоор Монгол Улсад яг аж ахуй эрхлэлт дээр эмэгтэйчүүдийн эзэлж байгаа байр суурийг илтгэх яг үнэхээр суурь судалгаа тоон мэдээлэл огт байхгүй. Зөвхөн захирлын хүйс бол эмэгтэйчүүдийн эдийн засаг дахь оролцоог бодитойгоор нь хэмжих хэмжүүр огт биш. Энэний цаана яг эдийн засгийн тэр үр өгөөжийг хэн хүртэж байна вэ гэдэг тоон судалгаа мэдээ Монгол Улсад өнөөдөр алга. Тийм учраас бид нар гишүүдээс бол маш их танхимын шугамаар гишүүдээсээ санал асуулгуудыг асууж байдаг. Тэгэхэд энд бол эмэгтэйчүүд маш их бид нар ийм зүйлээр тийм зүйлээр дутмаг гэж ярьдаг боловч энэ нь яг бодит байдал дээрээ ямар байгаа юм бэ гэдэг энэ статистик нь Монгол улсын хэмжээнд өнөөдөр байхгүй байна.

Хоёрдугаарт гэвэл яг бизнес эрхлэгчийн хувьд юуг мэдэрч байна вэ гэхээрээ ямар нэгэн төсөл хөтөлбөр зээл ямар нэгэн эдийн засгийн харилцаанд орохоор яг ААН маань жендерийн хувьд эмэгтэй, эрэгтэй энийгээ тодорхойлсон тодорхойлолтгүй учраас яг тодорхой бус байдалд бол хүрээд байгаа. Дээрээс нь ер нь эмэгтэйчүүд эдийн засгийн оролцоог нь бид нар яаж нэмэгдүүлэх гээд байгаа юм бэ гэхээр албан бус байдлаас нь нэгдэж нийлээд албан секи, албан ёсоор эдийн засгийн харилцаанд оролцоосой. Ингэх юм бол жишээлбэл том 30 гаруй жил бизнес Монгол Улсад хөгжлөө. Энэ хугацаанд том компаниуд жижиг ААН-тэй хамтарч ажилламаар байдаг, тэдгээр нь жалгын нэг харсан далд эдийн засагт орчихсон болохоор ямар ч чадавхгүй байгаа. Энийг шийдвэрлэх юм сан гэж зорьсон.

Дээрээс нь хамгийн гол нь эмэгтэйчүүдийн эдийн засгийн боломж нэмэгдэх юм бол улс оронд хүүхдүүдийн боловсрол, эрүүл мэнд, улс орны ирээдүйн хөгжилд энэ бол маш том түлхэц болдог гэдгийг дэлхий нийтийн туриллага харуулдаг учраас эмэгтэйчүүдийнхээ.../минут дуусав/

Г.Занданшатар: Хариулт нийт 5 минут байх ёстой л доо, тэгээд яг хугацаандаа тулчхаад товч тодорхой хэлэхгүй бол. 3 дээр нэмэх нь 2 гээд л 2 хүн л хариулна. Тодруулчихъя Доржханд, Тогмидын Доржханд гишүүн тодруулчихъя.

Т.Доржханд: Баярлалаа. Тэгэхээр дэмжиж байгаа, дэмжиж байгаа, дэмжихээс өөр арга байхгүй. Яагаад гэхээр олон улсад бол хамгийн их нөгөө зээл өглөө гэхэд үр ашигтай эргэж төлдөг тэр нөгөө сектор буюу бүлэг нь бол эмэгтэйчүүдийн бүлэг. Эмэгтэйчүүдийн бизнес эрхэлж байгаа тэр нь байдаг. Тэгэхээр энэ төслүүд бол маш сайн хэрэгждэг, сургалтаар хангадаг, хөнгөлөлттэй зээл өгдөг, бүлэглэдэг. Тэгээд хамтдаа нөгөө бизнесээ хийгээд үр дүнгээ хүртээд явдаг энэ бол болно сайн. Тэгээд энийг бас та бүгд ингээд хараад явж байгааг бол би хувьдаа бол бас их сайхан хүлээж авч байна.

Харин нөгөө асуултыг нөгөө тодруулж асуухад яг нэг санхүүгийн хувьд яг ямар байдлаар та нар хөнгөлөлтийг ингээд харж байгаа юм бэ? Татварын хувьд болохоор яг ямар байдлаар татварын хөнгөлөлтийг дэмжлэгийг авах ёстой гэсэн байдлаар харж байгаа юм. Тэгээд энэ нь нөгөө эргээд ажлын байрыг яаж өсгөх юм ч гэдэг юм уу тийм ээ, ийм байдлаар нэг тоо байвал хэлж өгөөч. Баярлалаа.

Х.Баасанжаргал: Нөгөө хуулийн тодорхойлолттой холбоотой бас асуулт учраас хуульчийнхаа хувьд хариулах нь

зөв байх гэж бодож байна. Нэгдүгээрт сая татварын хөнгөлөлтийн тухайд бид нар илүү татварын шинэ хуулиар болон Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуулиар орон нутгийн төрийн байгууллага нь өөрөө тодорхой хэмжээний бас татварын хувь хэмжээ тогтоох эрх нь оччихсон байгаа юм. Тэгээд тэр бүрэн эрхийнхээ хүрээнд энэ эмэгтэй бизнес эрхлэгчээ бас орон нутагтаа ингээд дэмжээч гэдэг ийм боломж байна гэж хараад байгаа юм. Тэгэхээр нөгөө дагалдаад Татварын хуулийн нэмэлт, өөрчлөлт энд ороогүй шалтгаан нь бас тийм учиртай гэсэн үг. Тэгэхээр нөгөө суурь татварын хуульдаа гар хүрэхгүйгээр, тэр боломжтой байж болох тэр хувилбарууд дээрээ эмэгтэй гэдгийг оруулаад ирээч гэсэн ийм хувилбараар энэ татварын хөнгөлөлтийг бол харсан байгаа юм.

Хоёрдугаарт гэвэл хуулийн тодорхойлолт болон энэ үндсэн агуулгаа бид нар анхдагч хуулиараа тодорхойлоод авчих юм бол бид нар нөгөө Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулиараа нөгөө хөгжлийн 6, 7 бодлого бид нар тодорхойлох ёстой байгаа. Тэгээд яг тэр нөгөө өргөн баригдаж байх энэ явцад бас дахиад илүү энэ хөгжлийн.../минут дуусав/

Г.Занданшатар: Оюунчимэг гишүүн 1 минут.

М.Оюунчимэг: Доржханд гишүүн маш чухал асуулт асууж байна. Энэ хэлэлцэх эсэхийг нь дэмжчихвэл хэлэлцүүлгийн явцад бид бас яг энийг улам сайжруулаад явчихна. Таны хэлээд байгаа тэр зээл, татварыг жишээ нь ямар зорилго бодлогоор оруулах юм, зээлийн хэдэн хувь байх юм ч гэдэг юм уу яаж тогтоох юм гэж асууж байгаа. Энэ маш зөв. Тэгэхээр сая бид нар жишээ нь ковид цар тахлын үед Арван их наядын нөгөө хөнгөлөлттэй зээл хөтөлбөр ингэхэд энд хамрагдсан эмэгтэйчүүдийн тоо маш бага байгаа байгаа байхгүй юу. Бараг ёстой 5 хуруунд, тэгэхээр 1 хүнд

ноогдсон тавин саяас хэтрэхгүй. Гэтэл нөгөө том компаниуд ч юм уу, эрэгтэй ААН-ийн эрхлэгч гэхээр хэдэн тэрбумаар болчихсон. Гэтэл 73 хувь нь эмэгтэйчүүд байгаад байгаа учраас бид квот тогтоовол зөв юм болов уу гэж жишээ нь бодож байгаа юм.

Одоо эмэгтэй бизнес аж ахуйн эрхлэгч гэдэг тодорхойлолтыг нь эхлээд яг тодорхой болгочоод, тэгээд Засгийн газраас хөнгөлөлттэй зээл юм уу, эсвэл арилжааны банк, Азийн хөгжлийн банк юм уу, аль нэг эх үүсвэр хөнгөлөлттэй зээлүүдийг олгох тохиолдолд яг бидний тодорхойлолтод багтсан аж ахуй эрхлэгч эмэгтэй яг энэ квотод нь оногдуулах ёстой гээд квот тогтоогоод өгчихдөг юм.

Г.Занданшатар: Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир, Сайнбуянгийн Амарсайхан нарын урилгаар Багануур дүүргийн иргэдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс сайн сайхныг хүсье. 5 гишүүний асуулт хариултын дараа асуулт хариултын цаг дуусаж санал хураалт явуулна. Гишүүд чуулганы танхимд цуглана шүү. Төмөртогоогийн Энхтүвшин гишүүн асуулт асууна.

Т.Энхтүвшин: Баярлалаа дэмжиж байна энийг. Ер нь Монгол Улсад энэ ААНБ эрхэлж байгаа нийт ер нь хэчнээн эмэгтэй байдаг юм бол гээд тийм судалгаа тоо баримт бас байдаг юм болов уу та хэдэд? Миний хувьд бол Үйлдвэржилтийн байнгын хороог ахалж байгаа. Тэгээд хамгийн тулгамдаж байгаа асуудал бол хуучин 2005 онд даавуун болон сүлжмэл эд эдлэлийг гааль НӨАТ-ын татвараас чөлөөлж байсан юм билээ. Тэр үед юу гэдэг юм оёдолчдын тоо 30000 хүрч байсан, эргээд юу гэдэг юм гааль НӨАТ-ын татвартай болсон даавуу болон сүлжмэл эдлэл маань.

Тэгээд 3800 хүртэл юу гэдэг юм оёдолчдын тоо буурсан юм билээ.

Тэгээд юу хэлэх гээд байна вэ гэхээр ер нь Монгол Улсад юу гэдэг юм хамгийн их юу гэдэг юм эмэгтэйчүүд эрхлэх бололцоо боломжтой ажиллавал энэ оёдол юм байна. Бид энэ оёдлын даавуу болон сүлжмэл бүтээгдэхүүнийг гааль болон импортын татвараас НӨАТ-аас нь чөлөөлөх ёстой юм байна. Ажлын байрыг нэмэгдүүлэх ёстой юм байна. 30000 оёдолчин оёдолчинтой болоод цаашидаа ч гэсэн бид нар юу гэдэг юм гадаадын тэр оёод байгаа бүтээгдэхүүнийг дотооддоо бас оёх ийм бол бололцоо боломж бас байна гэж харж байгаа. Энэ дээр та хэд маань бас юу гэж бодож байгаа юм бэ?

Сая манай Байнгын хороон дээр энэ оёдлын холбоонууд 2 ч томоохон хэмжээний албан бичиг өгсөн юм байна лээ. Ерөөсөө л энэ гааль, НӨАТ-ын татвараас чөлөөлж өгөөч. Ингэх юм бол юу гэдэг юм дотоодынхоо хэрэгцээг бүрэн хангахаар байна. Бүх төрлийн хувцсыг дотооддоо оёод, гадагшаа гаргах хүртэл бололцоо боломж байна. Ялангуяа Япон, Солонгосчууд хүртэл энэ оёдлын үйлдвэрүүдтэй бас уулзаад бид Хятадаас хамааралгүй болмоор байна. Танайд юу гэдэг юм бүтээгдэхүүнээ оёулъя гэдэг ийм хүртэл саналыг бас тавьдаг юм байна. Тийм учраас та хэд маань энэ дээр ямар саналтай байдаг юм бэ? Энэ саналыг хэрэв юу гэдэг юм манай эмэгтэйчүүд маань Үйлдвэржилтийн байнгын хороон дээр оруулаад ирвэл энийг Үйлдвэржилтийн байнгын хороогоор хэлэлцээд, Засаг руу бас энийг чиглэл өгч болох юм байна гэдэг дээр бас ийм зүйл байж байна.

Тэгээд цаашидаа бол бас энэ эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ялангуяа энэ ААНБ эрхэлж байгаа эмэгтэйчүүдийнхээ тоог нэмэгдүүлэх, тэднийг дэмжих нь бол бас зүй ёсны хэрэг байх гэж бодож байна. Баярлалаа.

Г.Занданшатар: 82 хариулна.

Р.Сансармаа: Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр Монгол Улсад бүртгэлтэй 147000 ААН-үүдээс зөвхөн гүйцэтгэх захирлынх нь тоогоор авч үзэхэд 37% нь эмэгтэй захиралтай ийм компаниуд байж байгаа. Гэвчиг энэ маань бол яг эзэмшигч, өмчлөгч эд нар гэсэн бол үг биш. Тэгэхээр манай улс бол хүний эрх, эмэгтэйчүүдийн эрх, жендерийн эрх тэгш байдалтай холбоотой олон улсын бүхий л гэрээ конвенц тэр дундаа Тогтвортой хөгжлийн зорилтуудыг баталсан хөтөлбөрт бол нэгдсэн байгаа. Тэгэхээр Монгол Улс уг хөтөлбөрийг баталсан улсын нэг болохын хувьд Тогтвортой хөгжлийн зорилтын үзүүлэлтүүдийн өгөгдлийг гаргах үүрэгтэй.

Тэгэхээр бид нар энэ хуулиараа яах гээд байна гэхээр энэ өгөгдлийг хүйсээр ангилсан өгөгдөл гэдэг юмыг Монгол Улсын хэмжээнд бий болгох юм сан гэж бас нэг зориод байгаа юм. Тэгэхээр мөн бас нэг зорилт нь болохоор Тогтвортой хөгжлийн зорилтын 5А дээр болохоор үндэсний хууль тогтоомжийн дагуу эмэгтэйчүүдэд эдийн засгийн нөөц эзэмших, тэгш эрх олгох, түүнчлэн газар болон бусад өмч санхүүгийн үйлчилгээ, өв залгамжлал, байгалийн баялгийг өмчлөх, хянах боломжийг бүрдүүлэх, шинэчлэл хийх гэсэн ийм зорилго үүргээ Засгийн газар 2 жил тутамд 1 удаа НҮБ-ын өмнө бол тайлагнаж байх ийм үүрэг хүлээчихсэн байж байгаа.

Тэгэхээр энэ хууль маань болохоор энэ үндсэн гол концепц нь болохоор энэ нэгдүгээрт бид нар тоотой больё, өгөгдөлтэй больё. Өгөгдөлтэй болохын тулд бид нар хамрах хүрээгээ ойлгох ёстой. Тэгэхээр бид нарын энэ тодорхойлолт буюу хэдэн хувийг нь өмчилж байвал эмэгтэй бизнес гэж ойлгох юм бэ гээд байгаа энэ тодорхойлолт маань бид нарын хамрах хүрээг тодруулаад өгчихнө гэж ойлгож

байгаа юм. Хамрах хүрээ тодорхой болохоор тэр хэмжээгээрээ тоолчихно. Тэгээд энэ.

Мөн Энхтүвшин гишүүний эмэгтэйчүүд эмэгтэй бизнес эрхлэгчдийн НӨАТ-ын татвар гэдэг юм уу, энэ татваруудыг дэмжлэгийн заалтууд оруулъя гэвэл ямар байгаа вэ та нарын бодол гэж байна. Бид нар бол энэ дээр маш баяртайгаар хүлээн авч энэ хуульдаа оруулахад бол бэлэн байж байгаа. Мөн манай улсын Үндэсний статистикийн хороо бол 2021-ээс 25 онуудад жендерээр ялгаатай бизнесийн өгөгдлүүдийг бол боловсруулах ийм хөтөлбөр төлөвлөгөө боловсруулчихсан байж байгаа. Тэгэхээр энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд бол хамрах хүрээ нь тодорхой байж байх л ёстой гэсэн үг. Тэгэхээр бид нар эмэгтэй бизнес гэж хэнийг тоолох вэ гэдгийг энэ стандартын үндэсний хороонд ч гэсэн энэ хууль маань чиглэл болоод явна гэж ойлгож байгаа. Баярлалаа.

Г.Занданшатар: Балжиннямын Баярсайхан гишүүн асуулт асууя.

Б.Баярсайхан: Баярлалаа. Өнөөдөр Монгол Улсын нийт хүн амын 51 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Гэтэл бид олон жил эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ гэж ярьсан. Яриад л байсан боловч энэ ажил төдийлөн бас үр дүнтэй байхгүй байгаа. Тийм учраас Улсын Их Хурал дахь эмэгтэйчүүд, эмэгтэй гишүүдийн бүлэг Аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн эдийн засаг дахь оролцоог нэмэгдүүлэх тухай хуулийн төслийг боловсруулан ингээд өргөн барьж байгаа юм. Энэ хуулийг батлан хэрэгжүүлснээр эмэгтэй бизнес эрхлэгчдэд олон улсын төсөл хөтөлбөрт хамрагдах, бизнес яаж хэрхэн хийхэд суралцах зээл тусламж авах зэрэг олон боломжууд бүрдэнэ. Одоогоор 46 дэлхийн 46 улсад энэ асуудлыг хуульчилсан байдаг. Өнөөдөр жишжиг, дунд бизнес эрхлэгчдийн 60 гаруй хувь нь эмэгтэйчүүд байна. Гэтэл ЖДҮ-г

дэмжих бодлого төсөв гээд л төрөөс бодлогоо хийгээд байдаг боловч боломж өгөөд байдаг боловч хэдэн том компани бизнесүүдийн хоол болоод дууссаныг бид нар бүгдээрээ харсан.

Энэ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан үнэхээр өнөөдөр хүндээ хүрч ажиллаж чадаж байна уу эсвэл зарим сантай адилхан ингээд хэдэн авлигачдын халаасыг түнтийлгээд дуусаж байгаа юм уу? Ер нь өнөөдөр Монголчууд сан гэж ярихаар бүүр айдаг болсон. Хэн нь хэдэн тэрбум төгрөг аваад, хэдэн төгрөг идээд уучихсан бол гэж өөрийн эрхгүй бодогддог болсон нууц биш. Өнөөдөр бас Монголд бизнес эрхлэх боломжгүй байна гэж бас хүмүүс ярьж байна. Бизнес тас хамгийн том садаа болж байгаа нэг хүчин зүйл бол төр өөрөө байгаад байгаа. Төрийн байгууллагуудын дарамт шахалт хэдэн мянган бүрдүүлэх баримт болсон, болоогүй стандарт гээд бизнес эхлүүлэх хөгжүүлэхэд хамгийн саад болж байгаа асуудал нэг талаар байгаа.

Сүүлийн үед Монгол Улсын Засгийн газар бас энэ ажилд нэлээн анхаарч төрийн бизнес эрхлэгчдээс эрхлэгчдэд төрөөс дарамт үзүүлэхгүй байгаа дээр бас анхаарч эхэлсэнд бас баяртай байна. Малчин тариаланч эмэгтэйчүүдийн орлогын эх үүсвэрийг төрөлжүүлэх, өрхийн үйлдвэрлэлд хөдөө аж ахуйд суурилсан бизнес эрхлэлт, өрхийн үйлдвэрлэлийг дэмжих зайлшгүй шаардлагатай байна. Өнөөдөр Монгол Улсад 150000 орчим мянган малчин, тариаланч эмэгтэйчүүд байна. Энэ хууль батлагдсанаар энэ хөдөө орон нутагт ажиллаж амьдарч байгаа малчин, тариаланч эмэгтэйчүүд нөхөрлөл хоршоо байгуулж, төр хувийн хэвшилээс санхүүгийн дэмжлэг авах бодитой боломж бүрдэнэ гэж ингэж найдаж байна. Албан бус сектор гэж нэг ийм сектор байна. Энд ажиллагсдын 56 хувь нь эмэгтэйчүүд байгаа. Жижиглэн болон бөөний худалдаа эрхлэгчдийн 60.9 хувь нь, үсчин, гоо сайханчдын 89.6 хувь нь эмэгтэйчүүд байгаа. Цай, хоол, байр

буудлын ажилчин, оёдол эсгүүр, барилгын засалчин гээд маш олон салбарт өнөөдөр эмэгтэйчүүд бор зүрхээрээ зүтгэж байна. Энэ хүмүүсийг яг хэзээ бодитоор төр дэмжих юм бэ?

Яагаад бор зүрхээрээ зүтгэж байна гэж хэлээд байгаа юм гэхээр энэ хүмүүсийн төлөө өнөөдөр дорвитой арга хэмжээ бид нар авч чадахгүй байгаа учраас яг амьдрал дээр хэрэгжихгүй байгаа учраас ингэж хэлээд байгаа юм. Албан бус гээд ингээд хаяглаад хаячихсан энэ салбар дахь эмэгтэйчүүдийн ард хэдэн ам бүл, хэчнээн хүүхдийн аж амьдрал явж байна. Жил бүр өсөж байгаа лангууны түрээснийх нь асуудлаар төрөөс юу ч хийхгүй байна. Барьцаа хөрөнгө байхгүй, албан ёсны зээл авах эрх боломж бүрддэггүй учраас өдрийн зээл авч мөнгө хүүлэгчдийн барьцаанд ингээд орчхоод байгаа ийм асуудал өнөөдрийн хамгийн тулгамдсан асуудал болж байгаа юм.

Хөгжлийн бэрхшээлтэй тусгай хэрэгцээтэй бага боловсролтой эмэгтэйчүүдэд бизнес эрхлэх боломжийг бас олгомоор байна. Яг өнөөдөр амьдрал дээр эдгээр эмэгтэйчүүд маань янз бүрийн бичиг баримт бүрдүүлж төсөл бичиж чадахгүй байна. Тэгэхээр энэ тал дээр бид нар бас шаардлагатай арга хэмжээг авах хэрэгтэй байна. Үүнээс гадна өнөөдөр Монгол Улсын хэмжээнд ажлаа хийгээд, хүүхдээ хараад, хүүхдээ зөөгөөд явж байгаа 66000 өрх толгойлсон эмэгтэйчүүд байна. Энэ хүмүүсийн төлөө бид нар бодитой хууль гаргаж, бодитой хэрэгждэг ийм үр дүнтэй ажлыг хийх цаг нь болсон гэдгийг хэлж байна. Тэгээд энэ хуулийн төслийг дэмжиж өгөхийг Их Хурлын эрхэм гишүүдээсээ хүсэж байна. Надад асуулт байхгүй, баярлалаа.

Г.Занданшатар: Үг хэллээ. Цэдэндамбын Цэрэнпунцаг гишүүн алга байна, хаслаа. Бадарчийн Жаргалмаа гишүүн асуулт асууя.

Б.Жаргалмаа: Баярлалаа. Энэ санал үг хэлэх биш асуулт асуух цаг учраас би бас ажлын хэсгийнхээ гишүүдээс бас мэдээллийг бас олон нийтэд илүү их дэлгэрэнгүй сайн өгөөсэй гэж хүсэж байна. Өөрөөр хэлэх юм бол энэ зөвхөн хууль батлагдсанаараа бид эрэгтэйчүүдийн хандлагыг өөрчилж, нийгэмд үзүүлэх эерэг нөлөөллийг улам бүр нэмэх энэ зорилгын хүрээнд бас энэ хууль маань орж ирж байгаа.

Түүрүүн Чинзориг гишүүн ч хэлсэн. Ийм хөлсгүй хөдөлмөр эрхэлж байгаа гэж үнэхээр эрэгтэйчүүдийг эмэгтэйчүүдтэй харьцуулах юм бол эмэгтэйчүүдийн хөлсгүй хөдөлмөр эрхэлж байгаа хувь нөхцөл байдлыг харах юм бол өндөр үзүүлэлт өндөр тоо гарч байгаа. Яагаад бид нар хөлсгүй хөдөлмөр эрхлээд байна вэ гэхээр яалт ч үгүй л хань ижлийнхээ хоол ундыг бэлдэх тийм ээ, үр хүүхдүүдээ өсгөх хүмүүжүүлэх, тэднийгээ сургах гэдэг энэ зүйл дээр илүүтэй их цаг гаргадаг болохоос бус бид ямар нэгэн байдлаар хөдөлмөрөө үнэлүүлээд, үл хөдлөх хөрөнгөтэй болоод, зээл авъя гэдэг энэ хандлага бас бидэнд байгаагүй нь бидний алдаа байж магадгүй. Тэгвэл энэ хуулийг баталснаараа энэ эмэгтэйчүүддээ бас боломж байгааг бид нар бас харуулахыг зорьж байгаа юм. Би энэ Жүр-Үр компанийн захирал маань сууж байна. Болормаа эгч маань сууж байна. Тийм ээ бүгдээрээ сайн жишгийг олон нийтэд илүүтэй их мэдээллийг өгөөч.

Сая ярилаа ЖДҮ болон Хөгжлийн банкнаас авсан зээлийн үр дүнд юу бид нар, эмэгтэйчүүд бүтээсэн юм. Ямар үр дүнтэйгээр бид нар зээлээ төлж чадсан юм. Энэ сайн мэдээлэл тоон мэдээллийг бас хэлээч гэж хүсэж байна. Өнгөрсөн жил бас СХД-тээ Сонгинохайрхан нэг төслийн хүрээнд ажилгүй байгаа гэртээ байгаа эмэгтэйчүүддээ ажил хөдөлмөр эрхэлдэг тэр боломжийг нээе, дүүрэгтээ ажилладаг Эмэгтэйчүүд хөгжлийн төвтэйгөө хамтран ажиллая гэсний үр дүнд бас тодорхой хэмжээнд оёдлын

машин авч эмэгтэйчүүдээ сургаж байгаа. Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбоо маань бараг хорь гаруй мянган хүнийг бас ажлын байртай болгох энэ боломжийг нээж өгсөн. Зөвхөн өнөөдөр сураад өнгөрөх биш тэд маань дараагийн алхмаа хийх, өөрсдөө үйлдвэрлэгч болох, үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнээ гадаад, дотоодод гаргах нийлүүлэх тэр зах зээлийг нь бид нар бий болгохын тулд хамтран ажиллаж байна дүүрэгтэйгээ.

Манай ЖДҮ, Эмэгтэйчүүд, хөгжлийн төвийнхөн болон Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбооныхон маань өөрсдөө Өвөр Монгол руу бараагаа зардаг, Улаан-Үүд рүү зардаг болж байна. Ийм сайн жишээнүүд маш их байгаа. Тэгэхээр энэ бүхэн дээр бид нар энэ хуулийг санаачлан боловсруулж оруулж ирж байгаа. Зүгээр эрэгтэй гишүүд маань бас дэмжиж үг хэлээд дэмжье гэдэг энэ санал хэлж байгаад бас талархаж байна. Энэ зөвхөн бид нар ямар нэгэн байдлаар хүйсээр ялгаварлаж эмэгтэйчүүдээ гээд онцлоод байгаа юм уу гэдэг дээр бас та бүхэн минь хариултыг өгөөрэй.

Яагаад гэвэл бид олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхийн тулд тийм ээ олон улсын хэмжээнд нэгдэн орсон конвенцынхоо шинэчлэлийг хангахын тулд бас энэ хуулийн төсөл өргөн баригдаж байгаа шүү гэдгийг хэлэхийг хүсэж байна. Тэгээд сайн жишээнүүдийг хэлээч. Өнөөдөр яг түүрүүн миний асуусан зээл тусламж аваад хэр үр дүнтэй байгаа юм бээ, хэчнээн хүнийг ажлын байртай болгочоод байгаа юм бэ? Энэ бол бидний давуу тал гэдгээ бид нар бас бахархан олон нийтдээ мэдээлэл өгөх ёстой байх гэж бодож байна. Миний асуулт энэ байна. Баярлалаа.

Г.Занданшатар: 85 Энхбаяр.

Т.Энхбаяр: Ажлын хэсгийн гишүүд маань нэмээд хариулна. Би эхний 1 минутад хариулчихъя. 3 асуудлаар

эмэгтэй аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн эдийн засгийн оролцоог нэмэгдүүлэх гэдэг маань бас үр дүнгээ өгнө гэж харж байгаа. Нэгдүгээрт нь нөгөө бид бүхэн хэлээд байгаа хөлсгүй хөдөлмөр буюу эмэгтэйчүүдийн маань гэрийн ажил болоод хөлстэй хөдөлмөр, хөлсгүй нөгөө хүүхдээ харах гэдэг дээр 2.4-өөс 3 дахин илүү цагийг бол бид нар цаг ашиглалтын судалгаагаар бол илүү эрэгтэйчүүдээсээ давамгайтай хийдэг байгаа. Гэхдээ энийг бид нар нөгөө хийх үүргээ татгалзах ерөөсөө асуудал биш. Монгол Улсын төрөөс бол энэ хүн амаа өсгөх бодлогыг хөдөлмөр эрхлэх бодлоготой ингэж нягт уялдуулах замаар бид нар Монгол өрх бүрийг орлоготой, орлого нь эдийн засагт нь хүртээмжтэй байх энэ чиглэлд бол анхаарах тусгайлсан ийм арга хэмжээ гэж ойлгож байгаа.

Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 7 дугаар зүйлд бол хэрэв аль 1 салбарт тэнцвэрт бус байдал үүсэж байгаа бол бид нар тусгай арга хэмжээг авч хэрэгжүүлж болно. Энэ бол Үндсэн хуульд заасан ялгаварлан гадуурхалт биш учраас үнэхээр эдийн засгийн оролцоо дээр эмэгтэйчүүдийн оролцоо маань дутмаг буюу хангалтгүй байгаа учраас энэ тусгай арга хэмжээ авах зохицуулалт маань уялдаж орж ирж байгаа юм.

Гуравдугаарт нь өнөөдөр та бүхэн бас мэдэж байгаа. Монгол гэр бүлийн өрхийн тэргүүний нуруун дээр үнэхээр эдийн засгийн үүрэг бол зонхилж явдаг. Энэ хандлагаасаа ч хамаараад өнөөдөр манай эрэгтэйчүүдийн дундаж наслалтын зөрүү 10 жилийн зөрөөтэй буюу эмэгтэйчүүдээсээ 10 жилээр бага насалж байгаа. Тэгэхээр өнөөдөр энэ Монгол гэр бүлд өрхийн тэргүүний эдийн засгийн үүргийг хуваалцах эмэгтэйчүүд өөрөө эдийн засгийн оролцоотой байх гэр бүлд бас энэ үүрэгтэй эн тэнцүү хамаарах, эхнэр, нөхөр бас хамтдаа тэтгэврээ аваад, дахиад энэ тэтгэврийнхээ үр шимийг хүртэж

хамтдаа наслах энэ асуудалд бол эрэгтэйчүүдийнхээ ажил, ар гэр амьдралын тэнцвэрийг хангахад эмэгтэйчүүдийн эдийн засгийн орлого бол гэр бүлд асар том үүргийг гүйцэтгэнэ. Энэ нь өөрөө ДНБ-д 16.1 хувийг хувь нэмэр оруулна гэсэн энэ олон улсын судалгааг өрх гэрийн түвшинд ингэж нотолж орж ирж байгаа юм. Баярлалаа.

Г.Занданшатар: Эхлээд зочид танилцуулчихъя Улсын Их Хурлын дэд дарга Лхагвын Мөнхбаатарын урилгаар Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын ерөнхий боловсролын сургуулийн 1995 оны төгсөгчдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Манай Улсын Их Хурлын дэд дарга Лхагвын Мөнхбаатарын нэг оны төгсөгчид бас сурагч ахуй насаа, эрдэмт багш нараа, гэгээн сургуулиа эргэн дурсахуйн уулзалт хийж ингэж уулзаж байгаа явдалд та бүхэндээ бас гэгээн дурсамж дүүрэн өдрийг өнгөрүүлэхийг хүсэн ерөөе. 81.

Л.Болормаа: Жаргалмаа гишүүний асуултад хариулъя. Мааш тодорхой эерэг жишиээнүүдийг би дурдъя гэж бодож байна. Манай банкны би бусад банкны системээр ярьж чадахгүй. Манай Голомт банкны том зээлдэгч муу зээлдэгч дотор нэг ч эмэгтэй байхгүй. Муу зээлдэгчдийн тоогоо жендерээр нь хуваахаар мөн ялгаа байхгүй. Эрэгтэйчүүд давамгайлж байгаа, эмэгтэйчүүд мааш бага байгаа. Мааш сайн зээлдэгчид байгаа. Тэр ч утгаараа Голомт банк манай өөрийн эх үүсвэрээрээ эмэгтэйчүүдийн тусгай бүтээгдэхүүн гаргасан байж байгаа шүү дээ.

Цаашилаад ярих юм бол сая бид нар Азийн хөгжлийн банкаар энэ ковидын эсрэг арга хэмжээ энэ дээр бол гэр хорооллын яг Чингэлтэй, Сонгинохайрхан, Сүхбаатар гэр хороолол дээр бол ингээд үйл ажиллагаа явуулахад ердөө 150-хан мянган доллароор тоног

төхөөрөмж авч өгсөн. Үнэндээ бол 79 өрхийн бизнесийнхэн сургалтуудаа яваад тэр тоног төхөөрөмжөө авч чадсан. Энэний үр дүнд 125 хүн ажлын байртай болсон. Энэ 125 хүн нь ажлын байртай болохоосоо гадна, хүчирхийлэл гэр бүлийн хүчирхийлэл байхгүй болсон. Дээрээс нь гэр бүлийн харьцаа маш сайжирсан.

Тэгээд цаашаа ингээд явах юм бол энэ хүмүүс маань хоршиж сурсан. 3 хоршоо сайн дураараа байгуулагдсан. Тэрнийхээ хэмжээгээр орлого нь нэмэгдсэн, зээлээ авч чаддаг болсон. Яагаад гэвэл ААН болсон учраас. Ингээд томроод хоршоод эхэлсэн учраас манай эмэгтэйчүүдийн зөвлөлөөс Оёдлын холбооноос хамгийн түрүүн ингээд дэмжээд явсан. Тэгэхээр яг энэ өмнөх гишүүдийн хэлснээр бид нар маш их талархаж байна. Оёдлын хоршооныхон, Оёдлын холбооныхон маань дан эмэгтэйчүүд байгаа. Гэр хорооллынхон бол дан эмэгтэйчүүд байгаа. Хэрэв бид нар тэр татварын асуудлыг шийдэх юм бол маш олон эмэгтэйчүүдийг ажилтай болгож болно, маш олон ААН-ийг дэмжиж болно.

Түүнчлэн Доржханд гишүүний асуулт 1 дутуу орхигдчих шиг болсон. Тэрүүн дээр бол эхлээд тодорхойлолтоо гаргаж байгаа бид нар бас энийг харсан. АНУ-д бол эмэгтэйчүүдийнхээ тодорхойлолтыг хууль болгож батлаад 97 онд, түүнийхээ дараа хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Өнөрболор гишүүний асуулт бас дутуу орхигдчих шиг болсон. Бүтцийн хувьд яаж явсан бэ гээд.../минут дуусав/

Г.Занданшатар: 1 гишүүний асуултын дараа санал хураалт явуулна. Гишүүд асуулт хариултын цаг дуусна. Гишүүд чуулганы танхимд цуглаарай. Цэдэвийн Сэргэлэн гишүүн асуулт асууя.

Ц.Сэргэлэн: Баярлалаа. Миний хувьд энэ хуулийг дэмжиж байгаа. Ийм хууль санаачлан оруулж ирж байгаа

эмэгтэйчүүддээ баярлалаа. Би тэгээд 1 асуулт байна, санал ч байна. Энэ хөдөө орон нутагт хөдөлмөрөөрөө хоршоолол хоршиж хоршоолол байгуулан ажиллаж байгаа манай эмэгтэйчүүд аягүй олон байдаг юм. Ялангуяа манай аймагт бол хөдөө сумдад малчин эмэгтэйчүүд хөдөлмөрөөрөө хоршоод хоршоолол байгуулчхаад ажиллаж байна. Тэгээд нэг л явж өгдөггүй, дэмжлэг байдаггүй ийм амьдралын бэрхшээлүүд олон байна. Оёдол оёдолчин эмэгтэйчүүдийн хоршоо гээд байж л байна, малчин эмэгтэйчүүдийн хоршоо гээд байж байна. Эд нарын гол хүндрэлүүд юу вэ гэхээр бүтээгдэхүүнээ борлуулах, зах зээлийн асуудал, хоёрдугаарт бүтээгдэхүүнийхээ хэмжээг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлээ өргөжүүлэхэд зээлийн асуудал барьцаа хөрөнгөгүйгээсээ болоод чаддаггүй ийм хүндрэлүүд байгаа. Энэ хүндрэлүүдийг төр бодлогоор энэ хуулиар дэмжих ийм асуудал энэ хууль дээр орж ирсэн үү гэдгийг нэгдүгээрт би асуухыг хүссэн юм.

Хоёрдугаарт ер нь та бүхэн ч мэдэх байх. Монгол Улсад маш онцлогтой цорын ганц 1 нэгж байдаг юм. Энэ бол Монгол Улсын хил дээр улсын хилийг хамгаалах үүрэг гүйцэтгэж байгаа хилийн застав отряд. Хилийн застав гэдэг энэ нэгж бол эмнэлэг, сургууль, цэцэрлэг, ясли, театр, музей, банк санхүү юу байдаг юм нийгмийн бусад ямар ч нэгж байдаггүй тэнд юу ч байхгүй. Зөвхөн улсын хил хамгаалалтын зориулалттай үйл ажиллагаа явуулдаг. Гэтэл тэнд халуун залуу сайхан насаа зориулж байгаа олон эмэгтэйчүүд бий. Энэ юу вэ гэхээр манай хилчин офицеруудын ахлагч нарын маань гэр бүлийн эмэгтэйчүүд. Энэ эмэгтэйчүүдийг тэр болгон ажлын байраар хангаж чаддаггүй хил хамгаалах байгууллага. Хангахын төлөө зүтгэдэг. Гэсэн ч энэ гүйцэтгэдэг үүргийн онцлогоос шалтгаалаад ажлын байраар хангаж чаддаггүй юм.

Тэгэхээр амьдрал баян учраас манай эмэгтэйчүүд амьдралаа авч явах, амьдралдаа бага ч гэсэн дэм тус болохын тулд застав дээр ажилгүй байгаа эмэгтэйчүүд маань ганц нэгээрээ хоёулаа нийлээд хувиараа хөдөлмөр эрхэлдэг. Сүү, цагаан идээ боловсруулдаг, жимс жимсгэнээр бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг, төмс хүнсний ногоо тариалдаг. Гэсэн хэдий ч энд зах зээл байхгүй учраас борлуулж чаддаггүй юм. Тэгэхээр үйлдвэрлэлээ бас өргөжүүлэх гэхээр зээл авч чаддаггүй. Барьцаа хөрөнгө ч алга тэд нарт, эргэлтийн хөрөнгө ч алга. Тэгээд үндсэндээ орхигдсон бүсгүйчүүдийн маань төлөөлөл тэнд байгаа шүү.

Хилчин эмэгтэйчүүдийн маань энэ хэсэг бүлэг ажилгүй байгаа, өөрсдөө эрвийх дэрвийхээрээ амьдралаа авч явахын төлөө чармайж байгаа энэ бүсгүйчүүдийн маань энэ хуульд тусгайлан төрийн бодлогоор дэмжлэг үзүүлэх ийм зүйл заалтуудыг оруулж өгөөч гэж би энэ хууль санаачлагч ажлын хэсгийн ахлагч та бүхнээсээ хүсэж байна. Энэ бол цорын ганц онцлогтой нэгж шүү. Өөр хаана ч ийм онцлог байхгүй. Дээрээс нь энд хүн ёсоор бодмоор 1 зүйл байдаг. Юу вэ гэхээр хүнд ганцхан заяах тэр сайхан залуу насаа тэнд өнгөрөөдөг юм. Энийг манай Сарангэрэл гишүүн маш сайн мэднэ. Тэгээд энэ утгаар нь би энэ хуульд манай тэр ажилгүй байгаа, ажил хийгээд ч гэсэн төрийн бодлогоос гадна үлдээд бор зүрхээрээ явж байгаа энэ хэдэн хилчин офицеруудын маань гэр бүлийн гишүүдийг тусгайлан дэмжих бодлогыг энд оруулж өгөөч гээд хүсэлт тавьж байгаа юм. Баярлалаа.

Г.Занданшатар:

Даваажсанцангийн Сарангэрэл гишүүн.

Д.Сарангэрэл:

Баярлалаа. Өнөөдрийн энэ Аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн эдийн засаг дахь оролцоог нэмэгдүүлэх тухай анхдагч хуулийн төслийн хэлэлцэх эсэхийг Улсын

Их Хурлаар шийдэх гээд бид хэлэлцүүлэг өрнүүлж байна. Тэгээд манай эдийн засагч, гишүүн Доржханд, Үйлдвэржилтийн байнгын хорооны дарга Энхтүвшин, манай хилийн цэргийн дарга байсан генерал, Улсын Их Хурлын гишүүн Сэргэлэн нар маань энэ эмэгтэйчүүдтэй холбоотой бизнес эрхлэлттэй холбоотой асуудалд ингээж ач холбогдол өгч анхаарч асуудалд хандаж байгаад үнэхээр талархаж байна.

Тэгээд дээр нь Улсын Их Хурлын дарга Занданшатар энэ асуудалд үнэхээр манлайлж байгаа. Анх хуулийн төсөл өргөн барихаас авхуулаад дэлхий нийтийн жишигийн талаар харин бидэнд бас санаа өгч, энэ хуулийн төсөлд санаа оноогоо оруулсан. Ер нь хийж бүтээе, үр хүүхдээ өсгөе, эрүүл мэнд, боловсролд нь өөрөө хөдөлмөрлөөд олсон орлогоо зарцуулъя, улмаар улс орныхоо эдийн засгийн хөгжилд хувь нэмрээ оруулъя. Олон улсад эмэгтэйчүүд хэрхэн яаж улс орноо хөгжихөд дэмжлэг үзүүлдэг вэ тэр жишигээр ажиллаж хөдөлмөрлөх ийм хүсэл эрмэлзэл Монгол Улсын хүн амын 51.3 хувийг эзэлж байгаа бүх эмэгтэйчүүдэд байгаа.

Бид 21 аймаг, 9 дүүргийн эмэгтэйчүүдтэйгээ газар дээр нь очиж уулзахад улс төр ярихаасаа илүүтэй бизнес эрхэлье, ажил хөдөлмөр эрхэлье, ашиг орлогоо нэмэгдүүлъя, хүүхдэдээ хүссэн зүйлийг нь аваад өгъе, улмаар улс орныхоо эдийн засагт хувь нэмрээ оруулъя, тийм хүчин чадал тийм хүсэл эрмэлзэл байна л гэж ингэж бидэнд илэрхийлсэн юм. Тэгээд үүнд бол манай Худалдаа аж үйлдвэрийн танхим бизнес эрхлэгч эмэгтэйчүүд энд хүрэлцэн ирсэн хуульч, статистикч, жендерийн гээд бүх төлөөллийн эмэгтэйчүүд маань 2 жилийн хугацаанд энэ хуулийн төсөл дээр ажиллаад ингээд өнгөрсөн намар бол бид нар сайхан өргөн барьсан.

Саяын миний энэ зүйлүүдийг хэлж байгаа нь төрийн бодлого төрийн дэмжлэг бол байгаа юм байна лээ

Сэргэлэн генерал. Парламентын тэргүүн дэмжиж байна гэдэг бол би энэ Монгол төрийн хамгийн том дэмжлэг байна гэж нэгдүгээрт ойлгож байгаа. Энэ дэмжлэгийн үр дүн бол ингээд гарах ёстой. Тэгэхээр энэ хуулийн төсөл хэрэв хэлэлцэх эсэх нь ишийдэгдээд, улмаар хууль төрлөө гэхэд бол энд хамрагдах нь зөвхөн том бизнес, дунд, жижиг дунд гэдэг юм уу ямар нэгэн ялгаа байхгүй. Бүх эмэгтэйчүүд хамрагдана. Тухайлбал таны хэлээд байгаа өөрийнхөө гэрийнхээ хүрээнд нэг ногоо дараад байгаа ногоо тариад байгаа тийм ээ, нэг жимсний чанамал хийгээд байгаа, тэгээд яаж борлуулахаа мэдэхгүй байгаа, зах зээлээ олохгүй байгаа тэр эмэгтэйчүүдийгээ нэгтгэж хоршоолох, улмаар компани байгуулах, өргөжих тэр боломжийг л нээх гэж бас энэ хуулийн төслийг санаачилсан юм байгаа юм. Тэгэхээр хамрах хүрээний хувьд бол манай хилчин бүсгүйчүүд, малчин эмэгтэйчүүд, өрхийн аж ахуй эрхлэгчид, жижиг, дунд бизнес эрхлэгчид манай амжилтад хүрсэн том бизнес эрхлэгч эмэгтэйчүүд үндсэндээ бүгд хамрагдах юм. Яагаад эмэгтэйчүүдийг дэмжье гэдэг асуудал яриад байна.../минут дуусав/

Г.Занданшатар: Энэ түрүүчийн асуултад 82, дараа нь 81 түрүүчийнхээ асуултыг гүйцээгээд хариулчхаарай 81-д. Мөнхзул билүү, 82 эхлээд.

Р.Сансармаа: Сэргэлэн гишүүний асуултад хариулъя. Ахицгүй хоршоо зөндөө их олон бичил бизнес эрхлэгч нар байна гээд эд нарт ямар үр дүн үзүүлэх юм бэ гээд асууж байна. Тэгэхээр хууль маань зөвхөн төрийн байгууллагаас эмэгтэйчүүдийг дэмжлэг авах тухай хууль бол биш. Энэ хууль боловсруулагдахдаа төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллагууд, эмэгтэйчүүдийн эрхэлж байгаа аж ахуй эрхлэлтийг яаж дэмжих вэ гэдэг талаар бүгдийг нь тусгасан байгаа. Тэгэхээр гуравласан байдлаар энэ оролцогч 3 тал гурвуулаа эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжинэ гэсэн заалтууд бол байж

байгаа. Энэ дээр тэр тусмаа сургалт явуулах, худалдан авалт хийх, бид нар компаниудын хууль боловсруулахад оролцсон компаниудын захирлуудын хувьд хэрэв энэ хууль батлагдаад гарах юм бол нэн тэрүүнд боломжит нөхцөлүүд нь бүрдсэн байлаа гэхэд эмэгтэй бизнес эрхлэгчийнхээ барааг худалдан авна гэсэн үг. Энийг бас хуульчлаад заачхаж байгаагаараа энэ хууль маань бас их онцлогтой болж байгаа.

Дээрээс нь бас офицеруудын эхнэр аллагдсан сумдад байрлаж байгаа энэ хүмүүс маань төр засаг маань бас энэ талаар нэлээн ажлууд хийж байгаа. Тэрний нэг дэмжлэгийн бодлого бол энэ шинэчилсэн Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хуульд бол яг энэ офицер, хилийн цэргийн удирдах ажилтнуудын гэр бүлийн хүмүүс бол нийгмийн даатгал, мөнгө халамж, тэтгэвэр эд нар авах тийм хууль заалтууд бол байгаа. Баярлалаа.

Г.Занданшатар: 81.

Л.Болормаа: Над дээр хамгийн сүүлийн асуулт үлдчихсэн байсан. Тэр нь бол бүтцийн тухай асуудал байсан. Тэгэхээр хуулийн тодорхойлолт батлагдсаны дараа хууль батлагдсаны дараа хөтөлбөр гарна гэж ярьсан. Тэгвэл тэр хөтөлбөр гарсны дараа тэрийг яаж хэрэгжиж байгааг хянах тэр зохицуулалт нь бол орон орноор өөр байж байгаа. Би зүгээр зөвхөн 2 орны жишээг хэлье гэж бодож байна. Америкийн Засгийн газрын жишээгээр бол тэнд бол яг энэ эмэгтэйчүүдийн өөрсдийнх нь энэ хөдөлмөр эрхлэлт яг энэ хуулийн хэрэгжилтийг хангадаг тийм агентлаг бол байж байгаа. Солонгосын улс Солонгосын жишээгээр бол сая бас тийм байгууллага байдаг гэдгийг бол хэлж байна. Тэгэхээр яах вэ ер нь бол бүтцийн асуудлыг энэ хууль хэлэлцэж байх үедээ бол дахин ярьж болох байх гэж би бодож байна. Тэгэхдээ энэ хууль

нь хэрэгжүүлэхийн тулд бас магадгүй тэр бүтэц нь шаардлагатай ч байж магадгүй л гэж үзэж байна. Мааш их баярлалаа.

Г.Занданшатар: 80.

Б.Мөнхзул: Жаргалмаа гишүүний асуултад Жаргалмаа гишүүний асуулт.../үг тасрав/

Г.Занданшатар: Протоколд үлдэх учраас уул нь овог нэр, ажлаа хэлээд яв. Тэгэхгүй бол наадах чинь протоколд үлдэнэ.

Б.Мөнхзул: Жаргалмаа гишүүний асуултад Жүр-Үр компанийн захирал, ажлын хэсгийн гишүүн Мөнхзул хариулж байна. Түрүүн сайн жишээ хэлээч гэсэн. Монголын эмэгтэйчүүд нийгмийн бүхий л салбарт амжилттай яваа. Бизнес дотор хамгийн топ зуун компанийн хувьд бол 10 гаруй хувь нь бол эмэгтэй захиралтай байгаа. Манай улсад хууль тогтоомж нь тодорхой биш учраас захирлын хүйсээр энэ бүхэн асуудал өнөөдөр яригдаж байгаа нь бас өрөөсгөл байгаа юм. Тэгээд эдгээрийн нэг нь бол би өөрөө байна. Гучаад жил бизнесийн салбарт ажиллаа. Тэгээд манай компани ёстой нөгөө жинс жижгээс өнөөгийн Жүр-Үрийг бид Монголчуудтайгаа хамтраад бүтээж байна. Эмэгтэйчүүдийн бизнесийн салбарт үзүүлдэг хамгийн гол нөлөө нь юу байдаг вэ гэхээр нэгдүгээрт.../минут дуусав/

Г.Занданшатар: Компанийн сурталчилгаа явуулахгүй шүү. Цэдэвийн Сэргэлэн гишүүн асуусан учраас тодруулсан.

Ц.Сэргэлэн: Баярлалаа. Яах вэ энэ тогтчихсон хоршоо компани юу байдаг юм энэ ААН-үүдийн хувьд бол эмэгтэйчүүдийн оролцоог бол төрөөс дэмжих юм байна гэдгийг би ойлголт авлаа. Энэ бол маш сайн. Энэ болгоны гадна байдаг орхигддог ганцхан онцлогтой салбар бол хилийн заставд

ажиллаж, ажиллах юу байх вэ амьдарч байгаа нөхрөө дагаад очсон цэл залуухан настай бүсгүйчүүд эд нарын маань тэр хоршоо байхгүй. Би хэлээд байна шүү дээ сургууль, цэцэрлэг, ясли юу ч байхгүй. Тэр буйдхан ертөнцөд халуун залуу насаа өнгөрөөж байгаа энэ хэдэн бүсгүйчүүдийг маань төр ивээлдээ аваад, амьдралд нь нэмэр болохуйц нэг ийм томоохон дэмжлэгийг өгөөч гэж энэ хуульд оруулж өгөөч л гэж би гуйгаад байгаа юм. Нийгмийн даатгалыг нь төлдөг гэж байна. Хөдөлмөрийн хөлсний хамгийн доод хэмжээгээр тооцоод нийгмийн даатгалыг нь төр төлж байгаа. Энэнээс өөр.../минут дуусав/

Г.Занданшатар: Сарангэрэл сайдаа, Сэргэлэн генерал, Сэргэлэн генерал хилийн заставын хар нүдэн бүсгүй гээд л яриад байгаа шүү дээ. Тийм. Тэгэхдээ яг энэ хуульд биш юм гэхэд өөр хуулиар эмэгтэйчүүд жендерийн энэ асуудал дээр бас орхигдож байгаа, хаягдаж байгаа, нийгмийн ялгаатай байдал, ялгаварлан гадуурхагдаж байгаа ажил мэргэжлийн онцлогоос энэ нөхцөл байдлын талаар бас ярих нь зүйтэй. Санал хураалт явуулна. Тэрний өмнө дэмжсэн, дэмжээгүй үг хэлж болно. Бат-Эрдэнэ гишүүнээр үг тасаллаа, Мөнхцэцэг гишүүнээр тасаллаа. Дараа нь санал хураалттай шүү гишүүд чуулганы танхимд. Цэрэнпунцаг гишүүнээр тасаллаа, эрэгтэй гишүүдийг оруулчихъя. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн, дараа нь Цэрэнжамцын Мөнхцэцэг, дараа нь Цэдэндамбын Цэрэнпунцаг.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа энэ оруулж ирж байгаа хуулийн төслийг бол дэмжиж байгаа. Эмэгтэйчүүдийн ажил хөдөлмөр эрхлэх, бизнес эрхлэх энэ боломжийг нь дэмжье гэсэн ийм агуулгатай хуулийг бол дэмжиж байгаа. Гэхдээ энэ ажлын хэсгээс сая хэлэлцүүлгийн үеэр хариулж байгаа байдлаас харах юм бол арай бас туйлируулж байгаа ийм зүйлүүд байгаа

юм биш биз дээ гэж. Ерөөсөө л эрэгтэйчүүд нь болдоггүй, бүтдэггүй, эсхүл хамаг юмыг аваад ингээд бариад суучихсан байдаг гээд нэг ийм хандлага байна уу, үгүй юу гэж. Арай ч бас ингээж туйлирч болохгүй байх гэж би ингээж ойлгож байгаа юм. Яах вэ манай нийгэмд байж байгаа бодитой зүйл бол намаар нь ялгаварладаг, нас хүйсээр нь ялгаварладаг, эр эмээр нь ялгаварладаг, шаашин шүтлэгээр нь ялгаварладаг, хөрөнгө чилээгээр нь ялгаварладаг. Одоо ерөөсөө хагалж ялгаваргүй юм үлдээгүй. Эхнэр, нөхөр хоёрыг хооронд нь сөргөлдүүлдэг, эцэг үг хоёрыг хооронд нь сөргөлдүүлдэг.

Г.Занданшатар: Сандаг-Очир, Өнөрболор 2 боль, суу. Булгантуяа битгий үймүүлээд бай.

Б.Бат-Эрдэнэ: Эх үр хоёрыг хооронд нь тэрсэлдүүлдэг. Ерөөсөө хагалаад үлдсэн юм ер нь байхгүй. Тэгээд нэг тийм хандлага та нар энэ ажлын хэсгийн улсуудын харцултаас харагдаад цухалзаад байхаар зэрэг би санаа зовоод ийм зүйлийг хэлж байгаа юм. Тэрнээс бол үнэхээр энэ чинь бид алхам тутамд л мэдэж байна шүү дээ. Нэг томдсон пиджакаа хасуулах санаатай захын оёдлын тасагт очиход л дандаа л эмэгтэйчүүд маань бүр тэтгэврийн насанд хүрчихсэн ч гэсэн өнөөдөр ажиллаад л, бүтээгээд л, хөдөлмөрлөөд л ингээд зүтгэж байгаа. Тэгэхээр энэ хувийн өрхийн энэ ЖДҮ-лэл, цаашилбал томоохон энэ бизнесийн салбарт бол үнэхээр эмэгтэйчүүд маань манлайлж байгаа. Эмэгтэйчүүдээ бид дэмжих ёстой, оролцоог нь нэмэгдүүлэх ёстой. Энэ дээр бол санал зөрөх юм байхгүй.

Монгол Улсын Их Хурлын дарга Япон лугаа хөгжье гэж энэ том уриалга дэвшүүлсэн. Энэ хүрээнд бид онлайнаар томоохон эрдэм шинжилгээний хурал хэлэлцүүлэг хийхэд бол Японы Цүкүбагийн их сургуулийн профессор Фүжита гэдэг профессор бол илтгэл тавьсан шүү дээ. Дайны дараах Японы

боловсролын тогтолцоо гээд. Тэгээд бид бол энэ сүйрэн унасан улс орноо яаж босгох юм бэ, хүнд аж үйлдвэрийг хөгжүүлнэ. Хүнд аж үйлдвэрийг хөгжүүлэхдээ бид нар химийн хүнд аж үйлдвэрийг хөгжүүлнэ гэж. Тэгээд энэ тогтолцоондоо бол боловсролын тогтолцоонд хөдөлмөр, гэр ахуй, биеийн тамир, урлагийн ийм хичээлүүдийг л гол түлхүү оруулна. Энэ нь яаж байгаа юм бэ гэхээр зэрэг хүний хөгжлийг хангах гол суурь нь юм гэж. Манайхан бол юу гэж ойлгох вэ гэхээр химийн хүнд үйлдвэр байгуулна гэх юм бол баахан химичид л бэлтгэх юм байна гэж ингээж л ойлгох байх л даа. Байгалийн шинжлэлийн чиглэлээр л гүнзгийрүүлэх ёстой юм байна гэж.

Гэтэл бол айлын хүүхдүүд айхтар учраас шал өөр бодлого гаргасан. Тэгээд тэрэн дээр нь бол энэ том зорилтыг биелүүлэхэд гэр хөдөлмөрийн хичээлээр ажиллах хүчнийг бэлдэнэ. Тэр ажиллах хүчний найдвартай ар талыг бид нар гэр ахуйн хичээлээр бэлтгэнэ. Хүнийг эрүүл чийрэг, бүтээлч ийм хүмүүнлэг хүнийг бий болгоход бол биеийн тамирын болоод урлагийн энэ хичээлүүд дээр энэ 3 хичээлүүд дээр л тулгуурлаж гэж ингээж хэлсэн. Тэгээд энэний дагуу бид нар бол улс оронд улс орон даяар хэрэгжүүлэхээр би хүмүүнлэг, эрүүл чийрэг, бүтээлч Монгол хүүхэд гэдэг ийм хөтөлбөрийг СӨБ цэцэрлэгийн наснаас нь эхлүүлээд, ЕБС-аар нь дамжуулж энэ хөтөлбөрийг хэрэгжүүлж гэж зорьж байгаа юм.

Тэгэхээр зэрэг эмэгтэйчүүдийн үүрэг оролцоо гэдэг бол асар их. Гэр бүлд ч гэсэн үр хүүхдүүдээ өсгөх, хүмүүжүүлэх, хүн болгох энэ том чухал үүрэг байгаа шүү. Тийм учраас энэ хуулийн зохицуулалт дээрээ.../минут дуусав/

Г.Занданшатар: Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүн.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр эмэгтэйчүүдийн эдийн засгийн оролцоог

дэмжих энэ хууль бол улс орны хөгжилд их том хувь нэмэр оруулна. Монгол Улсын өрсөлдөх чадварын индекс 2022 онд ойролцоо түвшний 63 улсаас 61-д орсон байгаа. Энэ өрсөлдөх чадварын индексэд нэг гол нөлөөлдөг үзүүлэлт бол жендерийн тэгш байдал, хөдөлмөрийн зах зээл дэх оролцоо байгаа. Мөн 2022 оны дэлхийн эдийн засгийн форумын тайланд Монгол Улс эмэгтэйчүүдийн эдийн засгийн болон улс төрийн оролцоо 3 функцээр буусан. Ер нь Монгол Улсын хөгжлийн гол индексүүд зардлын үзүүлэлтүүд дээр нэг уруу татаж байгаа нэг үзүүлэлт бол энэ жендерийн тэгш бус байдал, нийгэмд тэгш бус байдал. Тийм учраас Монголын төрөөс энэ эдийн засгийн болон бусад түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих зайлиггүй шаардлага байна.

Тэр дундаа Монгол Улс бол хүн ам цөөтэй, тэгээд өргөн уудам газар нутагтай, хөгжлийн потенциал, хүний нөөцийн потенциал багатай улсын хувьд бид нар хүн бүрийнхээ нөөц боломжийг хөгжил дэвшилдээ оруулах ёстой. Ингээд эмэгтэйчүүдийн боловсролын үзүүлэлт, хөдөлмөрийн ур чадварыг ингээд харахад бол маш өндөр түвшинтэй эрэгтэйчүүдээс давуу байгаа. Гэтэл яг хөдөлмөрийн зах зээл дэх оролцоо, шийдвэр гаргах түвшин дэх оролцоо бол үнэхээр доогуур байна. Энэ маань бид нар ингээд үндэстнийхээ хувьд ингээд харахад бол хүний нөөцөө бид нар бүрэн ашиглаж чадахгүй байна. Хөгжил дэвшил дэх тэр их боломжийг бид нар дутуу оруулж байна. Эмэгтэйчүүдээ дэмжих, эмэгтэйчүүдийн байх ёстой салбарт нь байршуулах, тэр дотор энэ сүүлийн жилүүдэд ер нь хөдөлмөрийн зах зээл дээрх эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо бол асар сул байна.

Сул гэдэг маань албан бус сектор, гэр орны хөдөлмөр хөлсгүй хөдөлмөр гэдэг юм уу эсвэл цагийн ажил, улирлын чанартай ажил гээд иймэрхүү салбар дээр эмэгтэйчүүдийн маань хөдөлмөрийн оролцоо байгаа болохоос биш яг тэр

хөрөнгө мөнгө төвлөрсөн, хамгийн их хөрөнгө оруулалттай гол салбаруудад бол маш ажиллах хүчний оролцоо бол их доогуур байна. Цалингийн зөрүү 18 хувьтай байна эмэгтэйчүүдийн. Энэ болгон бол ерөөсөө Монгол Улсын хөгжлийг хойш татах, тэр дундаа хүний хөгжлийг уруу татах хамгийн гол үзүүлэлт байгаа. Тийм учраас бид нар энэ эдийн засаг дахь аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдээ дэмжих энэ төсөл бол зөвхөн эмэгтэйчүүдэд ажлын байр бий болох, эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулах хөтөлбөр биш. Энэ бол Монгол Улсын хөгжлийн том нэг хүчин зүйл болно гэдэг ийм хэтийн төлөвт бол харж байгаа. Тийм учраас энэ хууль дээр бид нарыг анхаарч ажиллаж, ажлын хэсэг маань энэ энэ дээр бас судалгаануудыг бас сайн хийж өгсөн байгаа.

Ер нь бол Монгол Улс хөгжиж байгаа улсын хувьд бид нар хүн амынхаа бүх потенциалыг байж болох бүх хүний нөөцийг бол ашиглах ёстой. Тийм учраас энэ хуулийг ингээд Их Хурлын гишүүд маань хэлэлцэх эсэхийг дэмжиж өгнө гэдэгт бол найдаж байна. Тэгээд Монгол Улсын ирээдүйн хөгжилд бол тэгш байдалтай хүн бүрийн оролцоо тэгшээр үнэлэгдсэн, тэгээд улс орны эдийн засаг, боловсрол, хүний хөгжлийн гол үзүүлэлтүүд бид нар хүн ам цөөтэй улсуудын хувьд Скандинавын орнууд шиг ийм түвшинд хүрэх бүрэн боломж байна. Тийм учраас бид нар хүн амын 51.3 хувийг эзэлж байгаа эмэгтэйчүүдийнхээ бүх чадвар нөөцийг бүрэн ашиглах шаардлагатай байна.

Г.Занданшатар: Цэдэндамбын Цэрэнпунцаг гишүүн.

Ц.Цэрэнпунцаг: Энэ хуулийг дэмжиж үг хэлж байгаа юм. Түрүүн би бас асуулт асуух гэж байсан чинь харин хожигдчихож. Энэ эмэгтэйчүүд маань, Монгол эмэгтэйчүүд маань чадварлаг. Заавал нэг их дэмжлэг шаардаад байхгүй. Тэгэхдээ дэмжихээс аргагүй

нөхцөл байгаа юм. Яагаад гэвэл ялангуяа хөдөөгөөс сонгогдсон гишүүд бидний хувьд бол ялангуяа алслагдсан Завхан аймаг гэхэд энэ жижиг, дунд бизнесийг хөгжил гээд ярихаар гарцаагүй эмэгтэйчүүдийг ярихгүй бол болохоо байдаг юм. Ерөөсөө л өнөө очно, нөгөө жижиг, дунд бизнес эрхэлдэг хүмүүсээ цуглуулаад уулзал 70, 80, 90 хувь нь өнөө манай эмэгтэйчүүд. Тэгээд энэ эмэгтэйчүүд маань дандаа өндөр мэргэжилтэй. Их, дээд сургууль төгсчихсөн мөртөө энэ бизнес рүү ороод, тэгээд хөдөө одоо жишиэлбэл боловсролын чиглэлээр хувийн сургууль байгуулаад явах ч боломж муутай жишиэлбэл багш хүн гэхэд. Тэгээд л өөр чиглэл рүү орчихсон. Аягүй энэ өөрийгөө дайчилж, энэ талаараа суралцдаг, өөрийгөө боловсруулдаг. Ер нь ийм давуу талуудтай. Тэр нь эрэгтэй, эмэгтэйгээсээ болдог юм уу, үгүй юү бүү мэд. Ямар ч л байсан эмэгтэйчүүд маань ийм хөрвөх чадвар сайтай. Ингээд энэ багш байж байгаад өөр шал өөр бизнес хийгээд явчихсан. Ийм байдаг юм.

Тэгэхээр төрөөс бол гарцаа байхгүй бид нар ЖДҮ-лэлийн бизнесийг дэмжье гээд олон жил ярьсан. Манай жишиэлбэл Байнгын хорооны гишүүн, түрүүн энэ Ганбаатар сайд бол ЖДҮ-лэл бизнесүүдийг дэмжих чиглэлээр бол бас олон жил ярьж байгаа. Тэгэхээр зэрэг бол энэ өнөөдөр ийм хууль явж байгаа, гарч байгаа нь бол энэ чиглэлд хийгдэж байгаа том ажил гэж харж байна. Зүгээр эмэгтэйчүүд гэдэг утгаараа биш, жижиг, дунд бизнес гээд харчихад л эдийн засгийнхаа агуулгаас агуулгаараа бол энэ бол гарцаа байхгүй гарах болчихсон хууль гэж бодож байна. Тэгэхдээ бид нар нэг хуулийг гаргаад, тэгээд орхидог биш энэ хуулийнхаа хэрэгжилтийг араас нь явж, хэрэгжилтэд нь анхаарч, энэ хуулийн үр дүн яаж гарч байгааг бид нараас нь хянаж энэ Их Хурал хяналт шалгалтынхаа ажлыг сайн хийх хэрэгтэй.

Тэгэхээр бид нар энэ хуулийн энэ хамгийн гол нь үр дүнг нь үзэх ёстой. Тийм учраас бол бид нар энэ дээрээ бас энэ анхаарч ажиллах хэрэгтэй. Энэ дээрээ бас цөмөөрөө энэ ЖДҮ-лэл бизнес эрхэлж байгаа эмэгтэйчүүдтэйгээ хамтарч ялангуяа энэ чиглэлээр үр дүн яаж гарч байна, дахиад энэ хууль цаашидаа хэрэгжихэд яг практик амьдралд гараад хэрэгжихэд бас гарч болох сөрөг тал нь юу юм, дутуу хийгдсэн юм байдаг юм бол бас энийг гүйцээгээд ингээд төгөлдөржүүлээд явах ёстой ийм хууль гэж бодож байна. Тэгээд ингээд энэ хуулийг санаачилж орж оруулж ирсэн Улсын Их Хурлын энэ эмэгтэй гишүүддээ та бүхэндээ баярлалаа. Ингээд бүгдээрээ энийг нь эмэгтэйчүүд эмэгтэйчүүдийнхээ эдийн засагт оролцох оролцоог минь дэмжих энэ төрийн бодлогыг дэмжиж ингэж 100 хувь дэмжиж саналаа өгцгөөе гэж эрэгтэй гишүүддээ уриалж байна.

Г.Занданшатар: Баярлалаа гишүүд үндсэндээ уг хэлж дууслаа. Тэгээд ингээд Эдийн засгийн байнгын хорооны даргын хэлсэнчлэн эмэгтэйчүүдийн эдийн засгийн оролцоог дэмжих ийм чухал хуулийн төсөл санаачилсан гишүүд бас энэ ажлын хэсгийн гишүүдэд талархахын зэрэгцээ та хэд маань бас тоо баримтуудаа сайн нарийвчилж судалж бас мэдээллийн сангаа анхаарч ажиллахыг хүсэж байна. Мөнхзул ч гэсэн сая статистик тоо баримт байхгүй гэж хэлсэн. 10 хувь нь гэж байгаа топ ААН-үүдийн 27 нь эмэгтэй захиралтай, 10 хувь нь биш, 27 хувь нь гэсэн үг шүү дээ, 100-гийн 27 нь. ААН-үүдийн тооллогын дүнгээр идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа ААН-үүдийн 28.9 хувь нь эзэмшлээрээ өмчийн эзэмшлээрээ эмэгтэй бизнес, идэвхтэй үйл ажиллагаа бүртгэгдсэнийх нь 28.19 бол, идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа нийт ААН-үүдийн 31.2 хувь нь эмэгтэйчүүдийн эзэмшилтэй байгаа юм. ААН-ийн тооллогын дүнгээр энэ нийт идэвхтэй ААН-үүдийн 39.6 хувь нь эмэгтэй захиралтай.

Энэ дотроо харин Сэргэлэн гишүүний ч хэлээд байгаа нийт энэ хууль дотроо нэг анхаарах юм бол зүгээр хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа нийт иргэдийн 53.3 хувь нь эмэгтэйчүүд байгаа юм. Энийг хувиараа эрхлэх аж ахуй гэж үзэх үү, хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа эмэгтэйчүүд *entrepreneur*. Энийг бизнес гэж бас бичил бизнес эрхлэгчид гэж үзээд ингээд бас хамруулбал бас жинхэнэ нөгөө өрх толгойлсон эхчүүд ч байна, энэ олон эхчүүдийн энэ асуудал энд анхаарах ёстой байх. Яг энэ стандартаараа олон улсын стандартаар эмэгтэй бизнес гэдэг маань дээр нь нэмэгдээд нийт ажиллагсдынх нь 50-иас дээш хувь нь эмэгтэйчүүд бол эмэгтэй бизнес. Азийн хөгжлийн банк, Олон улсын санхүүгийн корпорацын тодорхойлолтуудаар бол эмэгтэй удирдлага. Өмч эзэмшлээрээ, өмчийн эзэмшлээрээ эмэгтэй эзэмшилтэй гээд. Энийгээ хууль дээрээ тодруулаад ингээд ажиллавал зүгээр.

Тэгээд статистик тоо баримт бол байгаа. ААН-ийн тооллогыг Статистикийн ерөнхий газар хийдэг тэр дотор байгаа. Тэгэхээр энийгээ бас сайн үзэх хэрэгтэй юм байна лээ. Тэгээд ер нь бас ялгаварлан гадуурхалт үүсэх үү гэж манай зарим гишүүд ярьсан. Тэгэхээр Дэлхийн эдийн засгийн форумаас гаргадаг жендерийн ялгаатай байдлын индексийг 4 үзүүлэлтээр дэлхийн 150 улсыг жагсаадаг. Манай улс нь эмэгтэйчүүдийн эдийн засгийн оролцоо боломжийн талаар үзүүлэлтээр 2022 онд 3 байр ухарсан байгаа. Монгол Улсад тулгарч байгаа энэ эмэгтэйчүүдийн эдийн засгийн оролцоо, бизнесийн орчин дахь жендерийн тэгш бус байдлын асуудал бол нийгэмд бодитой байгаа. Энд тулгамдаж байгаа асуудал нь энэ санхүүжилтийн асуудал сая яриад байгаа асуудал бол өмч хөрөнгийг өрхийн тэргүүн эрэгтэй хүний нэр дээр бүртгүүлэх хандлага түгээмэл байдаг учраас ААН эрхэлдэг эмэгтэйчүүд зээлийн барьцаа хөрөнгө хангалтгүй

гэсэн үндэслэлээр зээл санхүүжилт авч чадахгүй байгаа нэг дэх ийм асуудал байгаа юм. Тэгэхээр энэ чинь цаанаа бас өмчийн харилцаатай холбогдоно.

Хоёрдугаарт нь бол хөдөлмөрийн байран дахь ижил төстэй ажлын байрны хөдөлмөрийн үнэлгээний ажлын бүтээмж, хөдөлмөрийн үнэлгээний асуудал эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн цалин орлогын ялгаа, хандлагын ялгаа байгаа гэж. Тэгэхээр Жендерийн тэгш байдлыг хангах тухай хуулийн дагуу эрэгтэй, эмэгтэй хүний нийгмийн тэгш нийгэм, эдийн засгийн тэгш бус байдлыг арилгахын тулд авч хэрэгжүүлж байгаа тусгай арга хэмжээг бол ялгаварлан гадуурхалт, аль нэг хүйст давуу байдал олгосон гэж үзэхгүй гээд тодорхойлчихсон. Тийм учраас нэг эмэгтэйчүүдийг илүү үзэх гээд байгаа юм уу, харж үзэх гээд байгаа юм биш. Харин байгалийн онцлогоороо болон нийгмийн, эдийн засгийн энэ байгаа байдлаасаа шалтгаалаад эмэгтэй бизнес эрхлэгчид тулгарч байгаа бэрхшээл сорилтуудыг даван туулахад нь туслахуйц ийм хуульчилж, тодорхойлолтыг бий болгож, мэдээллийн сан бий болгож ажиллах нь бол дэлхий нийтийн хандлага болсон байна.

Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд дэмжлэг үзүүлэх тогтолцоог олон улсад хүлээн зөвшөөрсөн. Энэ чиглэлээр олон төсөл хөтөлбөрүүдийг ч гэсэн хэрэгжүүлж байна. Ийм тогтолцоог бий болгохдоо бол энэ жендерийн харилцан адилгүй нөхцөлөөс үүссэн тэгш бус байдлыг арилгахад чиглэх нь хуулийн хамгийн гол үндэслэл байх ёстой гэсэн ийм үндэслэлүүд байгаа.

Тэгээд санал хураалт явуулна. Байнгын хорооны саналаар Аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн эдийн засаг дахь оролцоог нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт,

өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Гишүүд анхааралтай байгаарай. Санал хураалт явуулъя. 27 гишүүн дэмжиж, 67.5 хувийн саналаар төслийг хэлэлцэх нь зүйтэй гэж үзлээ. Төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлж байна. Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлнэ. Нийгмийн бодлогын байнгын хороо шүү, Эдийн засгийн байнгын хороонд биш, Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлээ. Эдийн засгийн байнгын хороо дэмжиж байгаа учраас бараг шилжүүлчих шахлаа шүү дээ. Тэгэхээр Нийгмийн бодлогын байнгын хороо бүр л илүү дэмжих байх.

18.03 цаг

Ингээд 18 цаг болсон учраас өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.УЯНГА

